1.	Төв аймгийн Зүүнмод хотод дулааны станцыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх	Дулааны станцын өргөтгөл (2 дугаар шат, 32 МВт болон өргөтгөл, Сүхбаатар, Баруун-Урт)	974,600.0	ТЗЗУ-ийг боловсруулах	300,000.0	Барилга усралтын ажлыг эхлүүлэх	Барилга усралтын ажлыг дуусгах	200,000.0	Барилга усралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулах	ЭХЯ	Сумын ЗДТГ-ууд
2.	Цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх, өөрийн хямаруулах зорилгоор Сэлэнгэ аймгийн нутаг дахь Шүрэнгийн голын усан цахилгаан станцыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх	Цахилгаан эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлэх, өөрийн хямаруулах зорилгоор Сэлэнгэ аймгийн нутаг дахь Шүрэнгийн голын усан цахилгаан станцыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх	1,000.0	ТЗЗУ-ийг боловсруулах	300,000.0	Барилга усралтын ажлыг эхлүүлэх	Барилга усралтын ажлыг дуусгах	200,000.0	Барилга усралтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулах	ЭХЯ	Сумын ЗДТГ-ууд
<b>6.19. Ховд аймаг</b>											
4.	Эрдэнэбүрэнгийн Шижитийн усан цахилгаан станцыг барьж, ашиглалтад оруулах	Эрдэнэбүрэнгийн Шижитийн усан цахилгаан станцыг барьж, ашиглалтад оруулах	600,000.0	Зураг төсөл хийгдэх	150,000.0	Ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэх	Ажлын гүйцэтгэлийг 80 хувьд хүргэх	250,000.0	Ажлыг бүрэн дуусгаж, хүлээн авах	ЭХЯ	Аймгийн ЭДТГ
8.	Цэвэр, бохир усны 15 км газар доорх шулам шинэчлэлт /Жаргалант сум/	Цэвэр, бохир усны 15 км газар доорх шулам шинэчлэлт /Жаргалант сум/	4,500.0	-	2,000.0	Зураг төсийн зөргөж, ажлын гүйцэтгэлийг 50 хувьд хүргэх	Ажлыг бүрэн дуусгаж, улсын комисс хүлээн авах	2,500.0	-	БХБЯ	Аймгийн ЭДТГ
<b>6.20. Хөвсгөл аймаг</b>											
4.	Мөрөн хотыг тойрсон хөвсгөлийн үйлдвэр төхөөрөмжийн паркууд байгуулах	Цэвэр усны үйлдвэр байгуулах	1,500.0	Барилга баригдах	500.0	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг татах	-	-	-	Аймгийн ЭДТГ	ААН-ууд
<b>6.21. Хэнтий аймаг</b>											
3.	Хэнтий аймгийн Чингис хотод цэвэрлэх байгууламж шинээр барих	Хэнтий аймгийн Чингис хотод цэвэрлэх байгууламж шинээр барих	7,500.0	Барилга усралтын ажлыг эхлүүлэх	4,500.0	Барилга усралтын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах	-	-	-	БХБЯ	Аймгийн ЭДТГ



## БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАР

Барилга, хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар нь 2016 онд шинээр байгуулагдан хүн амыг орон сууцжуулах, ая тухтай амьдрах таатай нөхцлийг бүрдүүлэх, унд-ахуйн баталгаат усаар хангах, бохир усыг татан зайлуулж, цэвэршүүлэн байгаль орчны тэнцлийг хадгалах замаар хот, суурины өсөн нэмэгдэж буй дэд бүтцийн хэрэгцээ, нийгэм-эдийн засгийн тогтвортой хөгжлийн өсөлтийг хангах зорилгоор дараах чиг үүрэгтэйгээр үйл ажилагаагаа явуулж байна. Үүнд:

- Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, дүрэм, журам, норм, стандартын төсөл боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- агаарын бохирдлыг бууруулах, ногоон хөгжлийн бодлого, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийг зохицуулах;
- орон сууц, нийтийн аж ахуйн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг мэргэжи арга зүйн удирдлагаар болон салбар хоорондын уялдаа зохицуулалтаар хангах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх;
- орон сууц, нийтийн аж ахуйн салбарт шинээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн тооцоо судалгаа хийж, санал боловсруулах;
- салбарын суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэн гаргах, холбогдох байгууллага, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах, салбарын чиглэлээр бодлогын баримт бичиг боловсруулахад ашиглах;
- орон сууц, нийтийн аж ахуйн салбарын мэргэжлийн холбоо, төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах, хамтран ажиллах;
- салбарын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг удирдлага зохицуулалтаар хангах;
- салбарын байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах, тайлан, мэдээг нэгтгэн боловсруулах, холбогдох байгууллагуудын мэдээ мэдээллээр хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэх;
- нэгж дээр хэрэгжиж буй бодлого, төсөл хөтөлбөр, судалгааны талаарх мэдээллийн сан байгуулах, судалгааны үр дүнгээр төр, засгийн байгууллагыг мэдээллээр хангаж ажиллах;

Нийтийн аж ахуйн салбарын хөгжлийг салбар хоорондын бодлогын уялдааг холбож, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлж, нийтийн аж ахуйн салбар дах хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэн өрсөлдөх чадварыг сайжруулж, дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэн үйлчилгээний стандарт, чанар, хүртээмжийг дээшлүүлэн төр, шинжлэх ухаан, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын үр ашигтай хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.







## "МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБОО"

### Мэргэжлийн төрийн бус байгууллага

"Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоо" Мэргэжлийн төрийн бус байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2005 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 83 дугаар тушаалаар байгуулагдсан бөгөөд 13 дахь жилдээ үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.

Мэргэжлийн төрийн бус байгууллага болох Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбоонд аймаг орон нутгийн болон нийслэлийн ус суваг, орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын үйл ажиллагааг хариуцсан 65 гишүүн байгууллага байдаг.

#### Үндсэн үйл ажиллагааны чиглэл:

1. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын эрх зүйн зохицуулалт, бодлогын баримт бичгүүдийг боловсронгуй болгоход оролцох, хууль, дүрэм журам, норм стандартыг шинээр боловсруулах шинэчлэхэд мэргэжлийн үнэлэлт дүгнэлт гаргах, зөвлөгөө дэмжлэгээр хангах
2. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх
3. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын удирдлага болон инженер техникийн мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, ажиллагсадын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, чадавхижуулах, мэргэшүүлэх мэргэжлийн сургалт семинарыг мэргэжлийн байгууллага, сургалтын төвүүдтэй хамтран зохион байгуулах.
4. Мэргэжлийн гарын авлага, ном, сэтгүүлийг эрхлэн гаргаж гишүүн байгууллагуудаа хэрэгцээт мэдээ мэдээллээр хангаж, УИХ, Засгийн газар, салбарын яам, агентлаг, зохицуулах зөвлөл, төр засгийн бусад байгууллагатай хамтран, манай салбарт нэвтэрч буй шинэ техник технологи, үйл ажиллагааны талаар тогтмол мэдээллэж уншигч олондоо хүргэх.
5. Салбарын байгууллагууд мэдлэг, туршлагаа солилцоход дэмжлэг үзүүлэх зорилгоор сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг, айлчлал зохион байгуулах.
6. Салбарын ажлын чиглэлээр олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэнд оролцох, хөгжилтэй орны зорилго нэгтэй байгууллагатай хамтран ажиллах харилцаа холбоо тогтоох, тэргүүн туршлага, техник технологитой газар дээр нь танилцах урт богино хугацааны сургалт, айлчлалыг зохион байгуулах
7. Гадаад дотоодын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах.





## МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, МОНГОЛ УЛСЫН АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЪЯАТ АЖИЛТАН Б.ПҮРЭВЖАВ



Монгол улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан, Шинжлэх ухааны мастер, Монгол улсын зөвлөх инженер Бэсүд овгийн Бат-Очирын Пүрэвжав нь 1963-1973 онд Говь-Алтай аймагт бага болон бүрэн дунд боловсрол эзэмшсэн.

Тэрээр 1973-1974 онд Эрхүү хотын Техникийн их сургуульд бэлтгэл курс, 1974-1979 онд ЗХУ-ын Свердловск хотын Уралын Политехникийн дээд сургуульд суралцаж Ус хангамж сувагжуулалтын инженер мэргэжлээр дээд боловсрол эзэмшиж, 1987 онд Удирдах ажилтны дээд сургууль төгссөн, 1997 онд Япон улсын Нагоя хотод мэргэжил дээшлүүлсэн, 2002-2004 онд Англи улсын SURREY-ийн их сургуульд суралцаж Шинжлэх ухааны мастерын зэрэг хамгаалсан, 2008 онд АНУ-н Флоридагийн их сургуульд Дэд бүтцийн салбарын удирдлага зохицуулалтын курст суралцсан байна.

Б.Пүрэвжав нь 1979-1990 Нийтийн аж ахуйн үйлчилгээний яаманд техникч, мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, 1990-1992 Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт салбар хариуцсан референт, зохион байгуулагч, 1992-2005 Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газарт ерөнхий инженер, тэргүүн дэд дарга, 2005-2012 Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын дарга, 2012 оноос Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний холбооны гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.







## ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ЭРДЭНЭЖАВ ОВОГТОЙ ПҮРЭВЖАВ



Эрдэнэжавын Пүрэвжав нь 2002 онд Монгол Улсын Шинжлэх ухаан техникийн их сургуулийг Ус хангамж, ус цэвэрлэгээ мэргэжлээр төгссөн. 2003 онд ШУТИС-ийн Ус хангамж, ус цэвэрлэгээ мэргэжлээр магистрийн зэргээ хамгаалсан, 2011 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Бизнесийн удирдлага, нягтлан бодох бүртгэл мэргэжлээр тус тус дүүргэсэн. 2006 онд БСШУЯ Багшлах эрхийн

үнэмлэх, 2008 онд БХБ-н НАА-н үндэсний төв төсөвчний сургалт, 2012 онд ХБНГерман улсад бага хүчин чадлын цэвэрлэх байгууламжийн технологи, 2013 онд ЭМЯ Усны аюулгүй байдлын төлөвлөгөө, 2013 онд БХТөв Мэргэшсэн инженерийн чиглэлээр тус тус мэргэжлээ дээшлүүлсэн.

- 2003-2004 онуудад "Сан" ХХК-д Сантехникийн инженер,
- 2004-2010 онд Дон-Босго МСҮТ Сантехникийн ахлах багш,
- 2012-2013 онд БХБЯ Ус хангамж, ариутгах татуурга хариуцсан мэргэжилтэн,
- 2013-2015 онд Хараа голын сав газрын захиргааны дарга,
- 2015-2016 онд БХБЯ Инженерийн шугам сүлжээ хариуцсан мэргэжилтэн,
- 2016 оны 4-р сараас Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргаар ажиллаж байна.



## УЛААНБААТАР ХОТЫН УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА ЦОГСАЙХАН ОВОГТОЙ ТӨРХҮҮ



Улаанбаатар хот Сонгинохайрхан дүүрэг 2-р төрөх газар, Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг.Орос, Англи хэлтэй

### **Боловсролын байдал:**

1988-1998 онд Сонгинохайрхан дүүргийн 42-р дунд сургууль, 1998-2002 онд Хөдөө аж ахуйн их сургуулийн Газар зохион байгуулагч, инженер мэргэжлээр, 2002-2003 онд Их Британийн их сургууль, 2005-2007 онд Удирдлагын академийн Төрийн удирдлагын менежмент

### **Мэргэшсэн байдал:**

2005 онд Швед улсад Газар зохион байгуулалт, 2007 онд Герман улсад Газар зохион байгуулалт, төлөвлөлт, 2008-2009 онд Солонгос улсад Газрын нэгдмэл сан, 2010 онд АНУ –д Төрийн захиргааны чиглэлээр, 2011 онд Япон улсад Гамшгаас хамгаалах сургалтанд тус тус хамрагдсан.

### **Ажлын туршлага:**

- 2003- 2005 Сүхбаатар дүүргийн Газрын албанд Кадастрын мэргэжилтэн



- 2007- 2008 онд Сүхбаатар дүүргийн Газрын албанд газар зохион байгуулагч
- 2008-2009 онд Сүхбаатар дүүргийн Газрын албаны дарга
- 2009-2010 Сонгинохайрхан дүүргийн Газрын албаны дарга
- 2010- 2011 онд Нийслэлийн газрын албаны Кадастрын хэлтсийн дарга
- 2011-2012 онд Нийслэлийн газрын албаны орлогч дарга
- 2013- 2016 онд Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын орлогч
- 2016 оноос Ус сувгийн удирдах газрын дарга

**Сонгуульт ажил:**

Монгол ардын намын бага хурлын гишүүн, Нийслэлийн Монгол ардын намын гишүүн, Толгойт үе үеийн хөгжил ТББ-ын ТУЗ-ын дарга, 2016 оноос НИТХ-ын төлөөлөгч



**УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА ЖАМСРАНДОРЖ ОВОГТОЙ БАТСАЙХАН**



мэргэжлээр төгссөн. 2012-2014 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр, 2016 оноос доктрантураар суралцаж байна.

**Ажлын туршлага:**

- 1998-2003 онд "Машин Механизм" Хувьцаат Компанид захирал, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дарга
- 2005-2007 онд "Кибернетик" Банк Бус Санхүүгийн Байгууллагад гүйцэтгэх захирал
- 2015 онд Чингис Хаан Олон улсын нисэх буудлын Бизнес хөгжлийн газрын дарга
- 2016 оноос Орон Сууц Нийтийн Аж Ахуйн Удирдах Газрын дарга

Улаанбаатар хотод төрсөн. Эхнэр 3 хүүхдийн хамт амьдардаг. Англи, Орос хэлтэй

**Боловсролын байдал:**

1984-1994 онд Баянгол дүүргийн "Эрдмийн Өргөө" цогцолбор сургууль, 1994-1998 онд Хөдөө Аж Ахуйн Их сургуулийг кибернетикч мэргэжлээр, 1999-2003 онд Монгол Улсын Их Сургуулийг Эрх зүйч мэргэжлээр, 2004-2007 онд Хүмүүнлэгийн Ухааны их сургуулийг Англи хэлний орчуулагч

**Сонгуульт ажил:**

- 2012-2016 онд Нийслэлийн Баянгол дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч
- 2013-2016 онд Нийслэлийн Баянгол дүүргийн МАН-ын хорооны дарга
- 2016 оноос Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлыг тэргүүлэгч төлөөлөгчөөр ажиллаж байна.



# ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗРЫН 2016 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

## ЭРХЭМ ЗОРИЛГО

Хэрэглэгчийн ая тухыг хангасан үйлчилгээгээр тэргүүлэгч мэргэшсэн хамт олон байхад оршино.

## БИДНИЙ УРИА

Бидний үйлчилгээ таны ая тухын баталгаа

## МАНАЙ ГАЗАР



УЛААНБААТАР ХОТ **6 ДҮҮРЭГ**

УС ДУЛААН ДАМЖУУЛАХ **389 ТӨВ**

**815.8** КМ УРТ ДУЛААН, ЦЭВЭР БОХИР УСНЫ

ШУГАМААР ДАМЖУУЛАН



## МАНАИ АЖИЛТНУУД

Инженер техникийн ажилтнууд

Мэргэжлийн ажилчид

**90 ГАРУЙ ХУВИЙГ ЭЗЭЛЖ БАЙНА**

ХЭРЭГЛЭГЧДИЙН АЯ ТУХТАЙ АМЬДРАХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХЭЭР







ОСНААУГ–ын Техник үйлчилгээний хэлтэс тусгай зориулалтын 26 машин механизм ашиглан инженерийн шугам сүлжээнд гарч буй аваар саатал, гэмтлийг цаг тухай бүрт нь найдвартай шуурхай арилган ажиллаж байна.

## ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВАХ ТӨВ

Манай байгууллага оршин суугч, хэрэглэгчдийн тав тухтай амьдралын төлөө Дуудлага хүлээн авах төвийг ажиллуулж

**24 ЦАГИЙН ТУРШ**  **70005454**

тусгай дугаар дээр хэрэглэгчдийн дуудлагыг хүлээн авч өөрийн **3 Түгээх төв, 16 Хэрэглэгчдэд үйлчлэх төвөөр** дамжуулан эрэлт, хүсэлтийг нь шийдвэрлүүлэх, байгууллагын үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай хүргэж байна.

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг сайжруулах, хэрэглэгчийн дуудлага, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн гүйцэтгэлийг сайжруулахад байнга анхаарч ажилласны үр дүнд 2016 онд оршин суугч, хэрэглэгчдээс ирсэн дуудлага 2015 оноос 11.1%–иар, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн “Smartcity.mn” цахим програмаар ирүүлсэн өргөдөл гомдлын тоо 25.1%–иар, Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төвөөр дамжин ирсэн өргөдөл, гомдол 31%–иар тус тус буурсан байна.

## ДУУДЛАГА

Дуудлага хүлээн авах төв /70005454 дугаар/-д ирсэн эрэлт хүсэлт



## SMARTCITY.MN

Smartcity.mn сайтаар ирсэн өргөдөл, гомдол







## УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ

Улаанбаатар хотын шуурхай удирдлага зохицуулалтын төвөөр дамжин ирсэн өргөдөл,гомдол



2016 онд 16 Хэрэглэгчдэд үйлчлэх төвийг бүгдийг нь Дуудлага хүлээх авах төвд холбосноор хэрэглэгчдийн дуудлагыг нэгдсэн нэг сүлжээгээр хүлээн авч шийдвэрлэх, шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, гүйцэтгэлийн чанарыг дээшлүүлэхээс гадна:

- Дуудлагыг богино хугацаанд шийдвэрлэж, хариуг хурдан шуурхай өгөх боломж бүрдсэн,
- Дуудлага шийдвэрлэлтийн хяналт сайжирч, ажилтнуудын хариуцлага дээшилж, үйлчилгээний чанар сайжрсан,
- Цаг хугацаа болон зардлыг хэмнэсэн,
- Байгууллага, нэгж, ажилтан бүр дуудлага шийдвэрлэлтийн үйл ажиллагааг бодитойгоор үнэлж дүгнэх боломж нээгдсэн,
- Мэдээллийн технологийн дэвшилтэт технологийг хэрэглэгчдэд үйлчилгээг ойртуулсан,
- Иргэд, олон нийтийн дуу хоолой санаа бодлыг сонсох, тандан судлах зэрэг боломжууд бүрдлээ.

## ДУУДЛАГА ХҮЛЭЭН АВЧ БАРАГДУУЛАХ ҮЙЛ ЯВЦ



2016 онд ОСНААУГ–ын дуудлага хүлээн авах төв нь 70005454 тусгай дугаар ашиглан 231113 хэрэглэгчдээс ирсэн эрэлт хүсэлтийг хүлээн авч osug.callpro.mn цахим програмыг ашиглан салбар байгууллагын ээлжийн инженерт 58 секундэнд шилжүүлэн, шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллалаа.



## ТҮГЭЭХ ТӨВ

ОСНААУГ–ын инженерийн байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг болох дулаан болон цэвэр, бохир усны шугам сүлжээ, худаг, Ус дулаан дамжуулах төвүүдийн тоног төхөөрөмж, шугам сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах, ашиглалт, засвар үйлчилгээг осолгүй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зөрчилгүй, техникийн стандарт шаардлагын дагуу чанартай, шуурхай хийж гүйцэтгэн инженерийн байгууламжийн найдвартай ажиллагааг болон тоног төхөөрөмжийн ашиглалтын түвшинг дээшлүүлэх чиг үүргийг Түгээх төвүүдээр дамжуулан гүйцэтгэж байна.



## ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ

ОСНААУГ–ын хэрэглэгчдийг дулааны эрчим хүч, хэрэгцээний халуун, хүйтэн усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээг чанар, стандартын дагуу гүйцэтгэж шуурхай, соёлтой үйлчлэх үүргийг Хэрэглэгчдэд үйлчлэх төвүүд хүлээн ажиллаж байна.




## 2016 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛУУДЫН ТАЛААР ТӨВЧ ДУРДВАЛ

1

2293 айл өрхөд 6315 ш усны тоолуур шинээр суурилуулснаар эдгээр хэрэглэгчдийг бодит хэрэглээгээрээ усны төлбөрөө төлөх боломжоор хангалаа.

■ Тоолууржуулалтын хувь %







2017 онд нийт 3000 айл өрхийн усны хэрэглээг тоолууржуулах зорилт тавин ажиллаж байна. Усны хэрэглээг тоолууржуулснаар усны нөөцийг хэмнэхээс гадна 3 ам бүлтэй нэг өрхийн орон сууцны төлбөр жилд ойролцоогоор 170.0–200.0 мянган төгрөгөөр буурдаг.

2



Инженерийн шугам сүлжээнд гарсан нийт **452** авар саатлыг арилгахаар ОСНААУГ-ын **26** тусгай зориулалтын орчин үеийн машин механизм, давхардсан тоогоор **1100** орчим инженер техникийн ажилтнууд **1356** цагийн турш шуурхай ажиллан нийт **16.2** мянган айл өрх, хэрэглэгчийн ус, дулаан хангамжийг цаг алдалгүй хэвийн байдалд оруулсан байна.



Салбарын хэмжээнд **3** удаа нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулж нийт **310** хэрэглэгчдэд засвар үйлчилгээг **50** хувийн хөнгөлттэй үнээр хүргэж, хэрэглэгчдийн санал хүсэлтийг шууд хүлээн авч цаашдын ажлын төлөвлөгөөндөө тусган ажиллалаа.



3



Шинээр ашиглалтад орсон **2087** айл өрх бүхий **39** орон сууцны ашиглалт үйлчилгээг хариуцахаар хүлээн авч үйлчилгээний цар хүрээгээ нэмэгдүүлэн ажиллаж байна.

4





Ус хангамжийн шугам сүлжээнд даралт тохируулах хаалт суурилуулан илүүдэл даралтыг хязгаарлаж чадсанаар өмнөх оноос **817** мянган тонн ус хэмнэлээ.

5



6

ОСНААУГ өөрийн инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, оновчтой ашигласнаар **95** барилга байгууламжийг төвлөрсөн дулаан хангамжид, **100** барилга байгууламжийг ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд, **477** хэрэглэгчийг цахилгаан хангамжийн нэгдсэн сүлжээнд холболоо.

ОСНААУГ-ын хариуцан ажилладаг орон сууцны байруудын **35.6** хувь нь **1940–1980** онуудад баригдсан байрууд байдгаас ашиглалтын хугацаа нь дууссан инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмж нийт хөрөнгийн **51.0** хувийг эзэлдэг.



7



Гэвч хөрөнгийн эх үүсвэрээс шалтгаалан **2016** онд Засварын төлөвлөгөөний дагуу дулаан хангамжийн **7129** у/м, ус хангамжийн **1576** у/м, ариутгах татуургын **2128** у/м шугам сүлжээ, **9** орон сууцны байрын цахилгааны ерөнхий щитийг сольж шинэчиллээ.



Хамтран ажилладаг Сууц өмчлөгчдийн холбоодын эзэмшлийн инженерийн шугам сүлжээнд **76.8** сая төгрөгийн засвар үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

8



9



Өөрийн Хэмжих хэрэгслийн лабораторид **1655** хэрэглэгчийн **8276** ширхэг усны тоолуурыг хамгийн бага үнэ тарифаар баталгаажуулж үйлчилсэн байна.

10

Оршин суугч хэрэглэгчиддээ үзүүлдэг **210** нэр төрлийн засвар үйлчилгээнийхээ үнэ тарифыг зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үл хамааран сүүлийн **2** жилийн турш тогтвортой мөрдөн ажиллаж байна.

11

Хэрэглэгчдийн дуудлагыг **40** минутаас **1** цагт багтаан барагдуулж шуурхай үйлчлэх боллоо.

12

Хэрэглэгчдэд банкны үйлчилгээг ойртуулах, орлого төвлөрүүлэлтийг сайжруулах зорилгоор ХААН, Капитал банкуудтай хамтран ажиллаж эхэллээ.

## 2016 ОНЫ ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

2016 оны хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг нийт 10064 хэрэглэгчдээс авсан бөгөөд 7098 /70,5%/ хэрэглэгч бүрэн хангалттай, 2144 /21.3%/ хэрэглэгч хангалттай,

## МАНАЙ БАЙГУУЛЛАГЫН 2017 ОНЫ ЗОРИЛТ

ХЭРЭГЛЭГЧЭЭ ДЭЭДЛЭХ  
БАЙГУУЛЛАГАА ОЛОН НИЙТЭД ТАНИУЛАХ  
ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ НЭВТРҮҮЛЭХ  
САХИЛГА ХАРИУЦЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ





## АРХАНГАЙ АЙМГИЙН УСА-ЫН "УНДАРГА" ХХК-Н ЗАХИРАЛ БАЛДАНЦАН ОВОГТОЙ БУЛГАНЧИМЭГ



Архангай аймгийн Эрдэнэбулган суманд 1976 онд төрсөн.

Нөхөр 3 хүүхдийн хамт амьдардаг.

1994 онд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын 10 жилийн 2-р сургуулийг,

1998 онд МУИС-н Эдийн засгийн сургуулийн банкны ангийг тус тус дүүргэсэн. Банкны эдийн засагч мэргэжилтэй.

- 1998-1999 онд ХОТШ банкны ерөнхий ня-бо,
- 1999-2000 онд Нийгмийн даатгалын хэлтэст улсын байцаагч,
- 2001-2011 онд Хасбанкны захирал,
- 2011-2013 онд Капитал банкны захирал,
- 2013 оноос одоог хүртэл УСА-ын Ундарга ХХК-н захирлаар ажиллаж байна.



## "БАГАНУУР-УС" ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ МООНДОЙ ОВОГТОЙ БУДДОРЖ



1982 онд МУИС-ийг Цахилгааны инженер мэргэжлээр, 2003 онд Удирдлагын Академийг Бизнесийн удирдлагын менежерээр тус тус суралцаж төгссөн.

1999 онд Техникийн ухааны магистр, 2005 онд Монгол Улсын зөвлөх инженерийн зэрэг хамгаалсан.

- 1982 оноос Багануурын нүүрсний уурхайн харьяа Дулааны станцад инженерээр томилогдон 1992 он хүртэл инженер, хэсэг цехийн дарга,

- 1992-1997 онд Багануур Дүүргийн ЗДТГ-т мэргэжилтэн, хэлтсийн дарга, Засаг даргын орлогч,
- 1997-2000 онд Хишиг-Уул ХК-д дэд захирал,
- 2001-2002 онд ЗДТГ-ын Үйлдвэрлэл үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллаж байсан.
- 2002-2005 онд Багануур-Ус НӨҮГ-ын дарга,
- 2005-2008 онд Ганга Өргөө НӨҮГ-ын Ерөнхий инженер, дарга,
- 2008-2013 онд Багануур-Ус НӨҮГ-ын дарга,
- 2014-2016 онд Дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн нарийн бичиг, ажлын албаны дарга
- 2016 оноос Багануур-Ус ОНӨААТҮГ-ын даргаар томилогдон ажиллаж байна







## БУЛГАН АЙМГИЙН ДУЛААН УС ХАНГАМЖ НАА-Н "БУЛГАН –МЭЭЖ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ДОРЖСҮРЭН ОВОГТОЙ ОЧИРБАТ



1969 онд Булган аймгийн Булган суманд төрсөн. Эхнэр 2 хүүхдийн хамт амьдардаг.

- 1977-1987 онд Булган аймгийн Булган сумын 10-н жилийн дунд сургууль,
- 1991-1993 онд УБ хотын тээврийн сургуулийг нефть хангамжийн сав тоног төхөөрөмжийн механик мэргэжил,

- 2000-2001 онд Орхон аймгийн УТИСургуулийн Улс төрийн дээд ,
- 2003-2006 онд УБ хот ОУЭЗБДСургуулийн банк санхүүгийн нягтлан бодогч,
- 2015-2016 онд УБ хотын Удирдлагын академийн төрийн удирдлагын менежер мэргэжилээр төгссөн.

### **Ажлын туршлага:**

1989-1994 онд Булган аймгийн нефть хангамжийн баазад сав, тоног төхөөрөмийн засварчин, түгээгч, эрхлэгч, мөн ҮЭ-н хороон даргын сонгуульт ажлыг давхар хийдэг байсан.

- 2008-2012 онуудад Булган сумын ИТХ-н төлөөлөгч, тэргүүлэгчээр
- 2009 онд Булган аймгийн Булган сумын 6 дугаар багийн засаг дарга,
- 2016 оноос Булган аймгийн дулаан ус хангамж НАА-н "Булган-Мээж" ХХК-ийн гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.
- 2016 оноос Булган аймгийн ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгчөөр ажиллаж байна.



## БАЯНХОНГОР АЙМГИЙН "ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР" ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЭРДЭНЭЭГИЙН ЭНХБАТ



2001 онд Монгол Улсын Их сургуулийн Эдийн засгийн дээд сургуулийг нягтлан бодогч эдийн засагч мэргэжлээр төгссөн. 2010 онд Удирдлагын академи, 2016 онд Орхон их сургуулийг хууль зүйн магистраар тус тус төгссөн.

- 2001-2006 онд "Мерси кор" олон улсын байгууллагын говийн санаачилга хөтөлбөрийн төлөөлөгчийн хөтөлбөрийн газарт захиргаа санхүүгийн ажилтан,
- 2007-2012 онд Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газарт Санхүү, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын хэлтсийн дарга,
- 2012 -2016 онд Мэргэжлийн хяналтын газрын даргаар,
- 2016 оноос "Чандмань-Баянхонгор" ХК-ийн гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.

2009 онд "Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч" болж нягтлан бодогчийн зэрэг, цолоо нэмэн өөрийн санаачилгаар "Баянхонгорын Залуу санхүүчдийн холбоо" –г үүсгэн байгуулж залуучуудыг хөгжүүлэх, тэднийг дэмжих, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах зорилготойгоор 200 гаруй гишүүнтэй үйл ажиллагаагаа явуулан, холбооны тэргүүнээр сонгогдон ажиллаж байна. Мөн 2016 онд Аймгийн ИТХ-д төлөөлөгчөөр сонгогдон тэргүүлэгч, төлөөлөгчөөр ажиллаж байна.



### “БОР-ӨНДӨР ХОТ ТОХИЖИЛТ” ОНТҮГ-Н ЗАХИРАЛ БУЯННЭМЭХ ОВОГТОЙ ОЮУНЦЭЦЭГ



1982 онд МУИС-н ЭХФ-н холбооны инженерийн ангийг цахилгаан холбооны инженер мэрэгжилээр төгссөн.

- 1982-1987 онуудад Хэнтий аймгийн холбооны газарт хот хоорондын тасгийн эрхлэгч ШАТ-н инженер,
- 1987-1988 онд Дундговь аймгийн холбооны газарт ШАТ-н инженер,
- 1988-2015 онд Бор-Өндөр сумын холбооны салбарт эрхлэгч-инженерийн ажлуудыг тус тус хийж байсан.
- 2015 оноос Бор-Өндөр хот тохижилт ОНТҮГ-г захирлаар ажиллаж байна.

Инженерийн бакалавр зэрэгтэй. Тус байгууллагуудад ажиллаж байхдаа МУ-н онц холбоочин, хүндэт холбоочин цол тэмдэг, төрийн шагнал алтан гадас одонгоор шагнагдсан.



### “ГҮНИЙ-УС” ОНӨОХХК -ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЖАРГАЛСАЙХАН ОВОГТОЙ ЭНХЧИМЭГ



Ж.Энхчимэг нь 2009 онд ШУТИС Усан хангамж ус цэвэрлэгээ мэргэжлээр сантехникийн инженер 2011 онд Сэрүүлэг дээд сургуулийг нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн бизнесийн удирдлага мэргэжлээр 2015 онд ШУТИС-д барилгын инженер магистрын зэрэг хамгаалж 2016 онд Усан хангамж ариутгах татуургын системийн ашиглалтын мэргэшсэн инженерээр төгссөн.

- 2009 оноос "Гүний-ус" ХХК-д менежерээр
- 2011 онд дэд захиралаар
- 2015-н оноос эхлэн одоог хүртэл компаний Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.



### НААҮ-НИЙ “УСДУ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ БАТЦЭНД ОВОГТОЙ ГАНЗОРИГ



Б.Ганзориг нь 1998 онд Налайх дүүргийн ТИС лецей сургуулийг Цахилгааны инженер мэргэжлээр төгссөн. Улмаар 2011 онд мэргэжлээ дээшлүүлэн Отгонтэнгэр их сургуулийг Улс төр судлал мэргэжлээр суралцан төгссөн.

- 1998 - 2007 онд Говьсүмбэр аймгийн Эрчим хүчний үйлдвэрт Цахилгаанчин, зуухны мастер, ерөнхий инженерээр
- 2008 онд Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Талын-Илч ОНӨҮГ-ын захирлаар
- 2012 оноос НААҮ-ний УСДУ ОНӨААТҮГ-ын захирлаар ажиллаж байна.



## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН "СУАТ" ХХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЖҮСРЭН ОВОГТОЙ АДАЛБЕК



1985 онд Өлгий хотод төрсөн. 2003 онд Өлгий хотын 1-10 жилийн бүрэн дунд сургуулийг, 2008 онд Турк улсын Самсун хотын Ататуркийн нэрэмжит Ондокуз Майс Их сургуулийг сэтгэл судлал мэргэжлээр төгссөн. 2009 оноос 2013 онд Улаанбаатар Эрдэм Их сургуулийг багш, нийгмийн ажилтан-сэтгэл судлалын мэргэжлээр суралцаж боловсрол судлалын ухааны баклавын зэргээр төгссөн.

Турк, англи хэл эзэмшсэн. 2015 онд Иргэний улс төрийн боловсролын академийг бизнесийн удирдлагын менежер, мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дэргэдэх Төрийн удирдлагын академийг нийгмийн удирдлагын мэргэжлээр тус тус суралцаж төгссөн болно. ОХУ, БНХАУ, Турк улсуудад мэргэжил дээшлүүлж суралцсан. 2008 оноос "Жендеу констракшн" ХХКомпаний ерөнхий захиралын үүрэг гүйцэтгэж байгаагаас гадна нийгмийн болон улс төрийн ажилд чамдан оролцож 2010 оноос Монгол улсын казак залуучдын холбооны тэргүүлэгч гишүүн, 2014 оноос Баян-Өлгий аймгийн морин уяачдын холбооны тэргүүлэгч гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

- 2006 онд "Аймгийн шилдэг оюутан"
- 2009 онд МАОЗХолбооны "Алтан од" одон
- 2011 онд МЗХолбооны "Шилдэг залуу" алтан медаль
- 2014 онд "Аймгийн шилдэг бизнесмен"
- 2015 онд Аймгийн Засаг даргын жуух бичиг болон Алтанцөгц сумын "Хүндэт иргэн" тэнгэрийн тэмдэг мөн тус сумын 90 жилийн ойн хүндэт тэмдэгээр тус тус шагнагдсан болно.
- 2016 онд АИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон ба 2016 оны 09-р сараас эхлэн тус аймгийн "СУАТ" ХХК-ний гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.







## ГОВЬ –АЛТАЙ АЙМГИЙН НААУ-ИЙ “УНДАРГА-АЛТАЙ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ СҮХБААТАР ОВОГТОЙ БУЛГАНТАМИР



1980 онд Говь-Алтай аймгийн Алтай хотод төрсөн. 1998 онд Говь-Алтай аймгийн Алтай хотын Лодойдамбын нэрэмжит 2-р сургуулийг төгсөөд МУИС-ийн түүхч, түүхийн багш мэргэжлээр 2003 онд бакалавр зэрэгтэй төгссөн.

- 2003 оноос Солонгосын хөрөнгө оруулалттай Стар Шод ХХК-ий туслах менежерээр
- 2006 оноос УБ хотын Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын 7-р хорооны зохион байгуулагчаар,
- 2007 оноос тус хорооны нийгмийн ажилтан,
- УИХ-ын Тамгын газарт УИХ-ын дэд дарга Д.Идэвхитэний биет төлөөлөгчөөр
- 2008 оны 08-р сарын 11-ээс Петровис-Ник ХХК-ий Говь-Алтай аймаг дахь салбарын захирлаар 2016 оны 04-р сар хүртэл ажилласан.
- 2017 оны 01-р сарын 17-ноос НААУ-ий "Ундарга-Алтай" ОНӨААТҮГ-ын захирлаар томилогдон ажиллаж байна.



## “ДАРХАН-УС СУВАГ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ПУНЦАГ ОВОГТОЙ АРИУНДАЛАЙ



- 1991-1995 онд Баянзүрх хувиараа эрхлэх аж ахуйн захирал,
- 2000-2007 онд Дархан-Уул аймгийн Монгол ардын хувьсгалт намын улс төрийн ажилтан,
- 2008-2011 онд Дархан-Уул аймгийн Монгол ардын намын дэд дарга,
- 2011-2012 онд Дархан сумын Засаг даргын тамгын газарт Засаг даргын зөвлөх,
- 2012-2016 онд Дархан-Уул аймгийн Монгол ардын намын хорооны дэд дарга,
- 2016 оноос "Дархан-Ус суваг" хувьцаат компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



П.Ариундалай нь 1999 онд Дархан Өргөө коллежийг цахилгааны техникч мэргэжлээр төгссөн. Тэрээр 2003 онд Шинжлэх ухаан технологийн их сургуулийг цахилгааны инженер мэргэжлээр, 2005 онд Удирдлагын академийг Төрийн удирдлагын менежерээр төгссөн.



## “ЧАНДМАНЬ-ИЛЧ” ОНӨ ХХК-ЫН ЗАХИРАЛ ТӨМӨРБААТАР ОВОГТОЙ АЗБАЯР



2002 онд Монгол Улсын Их Сургуулийг Цаг уурын инженер мэргэжлээр төгссөн. 2004-2005 онд Удирдлагын Академийг Төрийн удирдлагын менежерээр төгссөн. 2010-2012 Монгол Улсын Их Сургуулийг

Цаг уурын магистрантурт суралцсан.

- 2002–2004 онд Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвд синоптик, холбооны инженер,
- 2005–2006 онд Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын орлогч,
- 2006–2009 онд Дорноговь аймгийн намын хорооны дэд дарга,
- 2009–2011 онд Дорноговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний албанд мэдээллийн сангийн инженер, Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга,
- 2006–2016 онд Од Аз ХХК-ий захирал,
- 2008–2017 онд Дорноговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгч
- 2016 оны 9-н сараас Чандмань-Илч ОНӨ ХХК-ын захиралаар ажиллаж байна.

Байгал орчны яамны "Хүндэт жуух бичиг", МЗХ-ны "Тэргүүний залуу" алтан медаль, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медалиар тус тус шагнагдсан.



## “ДОРНОД НИЙТИЙН АЖ АХУЙ” ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ГАНТӨМӨР ОВОГТОЙ БАЯРСАЙХАН



Г.Баярсайхан нь 2000 онд Дорно дахины гүн ухааны дээд сургуулийг судлаач багш, 2004 онд ШУТИС-ийг сантехникийн инженер мэргэжлээр тус тус төгссөн. 2014 онд Монгол дээд сургуулийг Бизнесийн удирдлагын магистр хамгаалсан.

- 2002-2005 онд Дорнод аймгийн "Дорнод Нийтийн Аж Ахуй" ХХК-ийн Техник шуурхай үйлчилгээний тасагт жолоочоор,
- 2005-2016 оны 8 дугаар сар хүртэл Техник шуурхай үйлчилгээний тасгийн даргаар,
- 2016 оны 8 дугаар сараас "Дорнод Нийтийн Аж Ахуй" ОНӨААТҮГ-ын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.





### “АМЬ-УС” ТРЕЙД ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ОЮУНБАТ ОВОГТОЙ БАТ-ӨЛЗИЙ



2009 онд Монголын Үндэсний дээд сургуулийг Гадаад худалдаа, гаалийн удирдлага мэргэжлээр төгссөн. Тэрээр 2010 онд Бизнесийн удирдлагаар магистр хамгаалж төгссөн.

2009-2012 онд Монголын Үндэсний дээд сургуульд "Менежментийн үндэс", "Эдийн засгийн онолын Багш,

- 2012-2013 онд "Батлан хамгаалах их сургууль" -д Багш,
- 2013-2015 онд Завхан аймгийн Татварын хэлтэст Байцаагч,
- 2015-2016 онд Нийслэлийн Татварын газарт Татварын улсын байцаагч,
- 2016 оноос Завхан аймгийн "Амь-Ус" трейд ОНӨААТҮГ-ын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



### “ЧАНДМАНЬ БАДРАЛ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ УХНА ОВОГТОЙ САНРАЙЖАВ.



Политехникийн дээд сургуулийг 1986 онд төгссөн. Мөн оноос эхлэн Дорноговь аймгийн Усны аж ахуйн байгууллагад ус хангамж, уст цэгийн засвар үйлчилгээний инженерээр 1996 он хүртэл ажилласан. 1997 оноос хувийн хэвшлийн салбарт авто тээврийн байгууллагын дарга эрхлэгчээр. 2013 оноос тус компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.







## “УРСГАЛ УС” ХХК-НИЙ ЗАХИРАЛ МӨНХБОЛД ОВОГТОЙ БАТБОЛД



2012 онд Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг Усан хангамж, Ус цэвэрлэгээний инженер мэргэжлээр төгссөн.

- 2012-2013 онд Сэлэнгэ аймгийн “Урсгал Ус” ХХК-ний Ариутгах татаургын албаны дарга, инженер,
- 2013-2016 онд тус компаний Усан хангамжийн албаны дарга, инженер,
- 2016 оноос “Урсгал Ус” ХХК-ний гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байна.



## УВС АЙМГИЙН НААУ-НИЙ “ЧАНДМАНЬ-УВС” ХХК-Н ЗАХИРАЛ МЯГМАР ОВОГТОЙ МӨНХӨӨ



М.Мөнхөө нь 2004 онд шинжлэх ухаан техникийн их сургуулийн ус хангамж ариутгах татуургын ангийг төгссөн. Тэрээр 2006 онд техникийн ухааны магистр хамгаалж 2017 оноос удирдлагын академийг төрийн удирдлагын менежерээр суралцаж байна.

- 2004-2006 онд НААУ-НИЙ Чандмань-Увс ХХК-д борлуулалтын байцаагчаар,
- 2006-2012 онд тус компанид ашиглалтын инженер,
- 2012-2015 онд ерөнхий инженер,
- 2016 оноос мөн компаний захирлаар тус ажиллаж байна



## “ХЭНТИЙ УС” ХХК-ИЙН ЗАХИРАЛ ГАНСҮХ ОВОГТОЙ БАТГЭРЭЛ



Г. Батгэрэл нь 2003 онд ХААИС, 2006 онд ОУЭЗБДС-ыг Эдийн засагч мэргэжилээр төгссөн. 2016 оноос Удирдлагын академийг Төрийн удирдлагын менежерээр суралцаж байна.

- 2005 оноос 2016 оны хүртэл Дэлхийн Зөн Монгол ОУБ-д эдийн засгийн зохицуулагчаар ажиллаж, гамшгаас хамгаалах, эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх олон төслийг гардан зохион байгуулж ажиллаж байсан.
- 2016 оноос “Хэнтий ус” ХХК-ны Гүйцэтгэх захирал албан тушаалд ажиллаж байна.



## СҮХБААТАР АЙМАГ “ДӨРВӨЛЖ” /ОНӨҮГ/ КОМПАНИЙН ЗАХИРАЛ ОНГУУ ОВОГТОЙ ДҮҮРЭНБИЛЭГ



Онгуу овогтой Дүүрэнбилэг 1965 онд Улаанбаатар хотын Амгалан гэдэг газар төрсөн.

1983 онд 1-р 10 жилийн бүрэн дунд сургууль, 1985 онд Санхүү эдийн засгийн техникумыг ХАА-н нябо, эдийн засаг, 2003 онд МУИС-ыг нягтлан бодогч, 2002-2003-онуудад Удирдлагын академийг Удирдлагын онол арга зүй, 2003 онд Бизнесийн удирдлагыг Бакалавр зэргээр тус тус төгссөн.

- 1985-1987-онд Сүхбаатар аймаг Баяндэлгэр сум Эх орны төлөө нэгдэлд туслах нябо ,
- 1987-1989-онд Өмнөговь аймаг АА-н 113-р ангид хугацааны цэрэг нябо,
- 1989-1990-онд Сүхбаатар аймаг Прокурорын газарт ерөнхий нягтлан бодогч,
- 1990-2001-онд Сүхбаатар аймгийн Зам ангийн ерөнхий нябо эдийн засагч,
- 2001-2003-онд Баруун-Урт хотын Санхүү тасгийн дарга,
- 2003-2005-онд Эрчим хүчний үйлдвэрт ерөнхий нябо,
- 2005-2007-онд Европын холбооны ТАСИС төсөлийн орон нутгийн зохицуулагч,
- 2007-2009-онд хөдөөгийн хөгжил ирээдүй төвийн ТББ-н тэргүүн,
- 2009-2011-онд Монгол даатгал компанид Дотоод ажлын менежер нябо,
- 2011-2013-онд Малын Индексжүүлсэн даатгал төсөлд Орон нутгийн зохицуулагч,
- 2013-2015-онд Соёмбо даатгал компанийн Сүхбаатар аймаг дахь салбарын захирал,
- 2015-2017 онд Сүхбаатар аймгийн МАН-ын хорооны Хяналтын хороон дарга, 2017 оноос Сүхбаатар аймгийн "Дөрвөлж" ОНӨҮГ-ын даргын албан тушаалд одоог хүртэл ажиллаж байна.



## “ЦАНТ ОРХОН” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ДАШПИЛ ОВОГТОЙ БАТ-ЭРДЭНЭ



Д.Бат-Эрдэнэ нь 1974 онд Сэлэнгэ аймгийн Мандал суманд төрсөн.

1990 онд Мандал сумын IY сургууль төгсөж, 1993 онд Монгол улсын Багшийн коллежийг багш мэргэжлээр төгссөн. Тэрээр 1999 онд Улсын багшийн их сургуулийг Монгол хэл-Уранзохиолын багшаар, 2007 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академийг "Нийгмийн удирдлагын менежер"-ээр төгссөн.

- 1993-2000 он Мандал сумын Хэрх-IY сургуульд багш,
- 2000-2012 он Мандал сумын I сургуульд багш,
- 2012 оноос "Цант Орхон" орон нутгийн өмчит компанийн гүйцэтгэх захирлаар одоог хүртэл ажиллаж байна.



## “ТӨВ ЧАНДМАНЬ-ДЭХ” ГАЗРЫН ЗАХИРАЛ ЦЭРЭНДОРЖ ОВОГТОЙ ЖАМБАЛСҮРЭН



1973 онд Төв аймгийн Баянцогт суманд төрсөн. 1981-1991 онд Баянцогт суман ерөнхий боловсролын сургууль, 1991-1995 онд УБИСургуулийг физик, электроникийн анги, 1993-1997 онд Улс төрийн их сургуулийг Эдийн засагч мэргэжлээр, 2006-2008 онд Улаанбаатар их сургуулийг Түүхийн ухааны магистр, 2013-2015 онд Удирдлагын академийг Төрийн захиргаа удирдлагын магистраар тус тус төгссөн.

- 1992-1994 онд Баянцогт сумын 10 жилийн сургуульд физикийн багш.
- 1997-2010 онд Дунд-Урт ХХК-ний ерөнхий захирал.
- 2010-2010 оэнд Дунд-Урт группийн ерөнхийлөгч.
- 2012 оноос МҮХАҮТанхимын тэргүүлэгч, удирдах зөвлөлийн гишүүн, Төв аймаг дахь ХАҮТанхимын дарга
- 2016 оны 10 сараас Төв аймгийн Төв Чандмань-ДЭХГазрын захирлаар ажиллаж байна.



## ХОВД АЙМГИЙН НААҮ-НИЙ “ШИМ-УС” ОНӨААТҮГ-ЫН ДАРГА ДАШЦЭРЭН ОВОГТОЙ НЯМЛХАГВА



- 2013 оноос НААҮ-ний "Шим-Ус" ОНӨААТҮГ-ын даргаар ажиллаж байна.

### **НААҮ-ний ажлын чиглэлд:**

Найдвартай, найрсаг, шуурхай үйлчилгээ үзүүлэхэд анхаарч ажилладаг. Ховд хотын нийтийн орон сууцны салбар шугам, хаалтын найдвартай байдалд шинэчлэл хийн ажиллахын зэрэгцээ байгууллагын материаллаг баазын бэхжилтнд чанартай багажаар шуурхай үзүүлэхэд анхаардаг.

Хотын өсөн нэмэгдэж байгаа ачаалалд тулгуурлан аймгийн иргэдийн хурал, засаг даргатай хамтран шинжлэх ухааны тооцоонд тулгуурлан шугам сүлжээний зохистой сүлжээг бий болгохоор хамт олонтойгоо хамтран зүтгэж байна.

2004-2008, 2012-2016 ,2016 оноос Ховд аймгийн ИТХ-ын төлөөлөгч төрийн дархан түшээ юм.

1972 онд төрсөн 1990 онд Ховд аймгийн 1-р 10 жил, 1996 онд ТИС-ийг геологич мэргэжлээр, 2009 онд Эрдэм дээд сургуулийг эрх зүйч мэргэжлээр 2011 онд удирдлагын акедимыг "Төрийн удирдлага"-аар тус тус төгссөн.

Эхнэр, хүү, охидын хамт амьдардаг.

- 1997-1998 онд Дацан трейд ХХК-ны Хэнтий аймаг дахь хайгуулын ангийн дарга,
- 2000-2001 онд Ховд эрдэм дээд сургуулийн захирал,





## “ХӨВСГӨЛ УС СУВАГ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ГҮРЭЭ ОВОГТОЙ ЭНХБАЯР



Г.Энхбаяр нь 1988 онд Политехникийн дээд сургуулийг Усан хангамж, ариутгах татуургын инженерээр төгссөн. Тэрээр 1999 онд Техникийн ухааны магистр, 1999 онд Зураг төсөл зохиох хүрээнд Тэргүүлэх инженер, 2004, 2007 онд Усан хангамж, цэвэрлэх байгууламж, ариутгах татуургын системийн угсралт, засварын ажлын хүрээнд бүтээл хамгаалан Мэргэшсэн инженерийн зэрэг авч, сунгаж хугацаагүй эрхийн гэрчилгээг авсан.

2009, 2012, 2016 онд барилгын онд Барилга, байгууламжийн угсралт, засварын ажлын хүрээнд Мэргэшсэн төсөвчний зэргийг авч, сунгаж хугацаагүй эрхийн гэрчилгээ авсан. Мөн 2013 онд Монгол улсын Зөвлөх инженерийн зэргийг Ус хангамж, ариутгах татуургын системийн угсралт, засварын ажлын хүрээнд бүтээл хамгаалж авсан.

- 1988-1998 онд Хөвсгөл аймгийн Инженер хайгуул, зураг төсвийн товчоонд зургийн инженерээр,
- 1998-2005 онд Хөвсгөл аймгийн Ус суваг нийтийн аж ахуйн компанид механик инженер, ашиглалтын инженерээр,
- 2005-2016 онд ерөнхий инженерээр тус тус ажиллаж байсан.
- 2016 оноос "Хөвсгөл Ус Суваг" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



## “ГАВШГАЙ-УС” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ЛХАГВА ОВОГТОЙ БАЛДОРЖ



Л.Балдорж нь 1983 онд Политехникийн дээд сургуулийг цахилгааны инженер мэргэжил эзэмшин төгссөн. Тэрээр 1997 онд ШУТИСургуульд ТУМагистр зэрэг хамгаалж, улмаар 2000 онд Герман, 2007 онд Япон, 2011 онд Солонгос улсуудад тус тус мэргэжил дээшлүүлсэн.

- 1984 онд ББМУЯ-ны томиллоор Хөтөлийн ЦШК-д ирж Дулааны станцад Цахилгааны инженерээр,
- 1987 оноос Ерөнхий энергитикээр ажиллаж байсан.
- 1997 оноос одоог хүртэл Хөтөлийн "Гавшгай-Ус" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна



## “ДУЛААН ШАРЫН ГОЛ” ТӨХК-ИЙ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ БЯМБАА ОВОГТОЙ ЭНХЦЭЦЭГ



Б.Энхцэцэг нь 1989 онд Политехникийн дээд сургуулийн цахилгааны инженер мэргэжлээр төгсөж, 1999 онд техникийн ухааны магистр хамгаалан 2003 онд Удирдлагын академийг Бизнесийн удирдлагаар төгссөн.

- 1989-2005 онд Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх хувьцаат компаний Шарын гол салбарын дарга,
- 2005-2009 онд Шарын гол хувьцаат компаний хангамжийн менежер,
- 2009-2013 онд Дулаан Шарын гол төрийн өмчит хувьцаат компаний гүйцэтгэх захирал,
- 2013-2016 онд Шарын гол сумын Засаг даргын орлогч даргаар ажиллаж байсан.
- 2016 оноос Дулаан Шарын гол төрийн өмчит хувьцаат компаний гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



## “ЧАНДМАНЬ НАЛАЙХ” ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ ГЭНДЭНДОНДОВ ОВОГТОЙ ЧУЛУУНБАТ



1974-1979 онд Монгол Улсын Их Сургуулийн Барилга инженерийн факультетийг Барилгын сантехникийн инженер мэргэжлээр төгссөн. Дээд боловсролтой. Сантехникийн инженер мэргэжилтэй.

Г.Чулуунбат нь 1979-1985 онд Налайхын нүүрсний уурхайн Дулааны станцын инженер дарга, уурхайн засвар хариуцсан механик, материал техник хангамж хариуцсан орлогч дарга, 1985-1998 онд Налайхын Нийтийн Аж Ахуйн Үйлчилгээний Газрын дарга, 1998-2001 онд Налайхын Дулааны станцын дарга, 2001-2004 онд Налайхын дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, 2004-2008 онд Төв аймгийн Баян сумын Засаг дарга, 2009-2012 онд Налайх дүүргийн 109-р бага сургуульд механик, 2012 оноос "Чандмань Налайх" ОНӨААТҮГ-ын захирлаар одоог хүртэл ажиллаж байна.



## ОРХОН АЙМГИЙН "ЭРДЭНЭТ УС ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ОНӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ДАШДОРЖ ОВОГТОЙ БҮҮВЭЙБААТАР



Д.Бүүвэйбаатар нь 1994-1998 онд Улаанбаатар хотын Нягтлан Бодох Бүртгэлийн Мандах Дээд сургуульд нягтлан бодогч мэргэжлээр суралцаж бакалавр зэрэгтэй төгссөн байна. 2006-2007 онд

Улаанбаатар хотын Удирдлагын академид суралцаж нутгийн удирдлагын менежерээр мэргэшиж төгссөн. 2015-2017 онд Хүмүүнлэгийн ухааны сургуульд бизнесийн удирдлагын магистраар суралцаж байна.

- Эрдэнэт-Сэлэнгэ ХХК-д нягтлан бодогчоор
- 1998-2000 онд тус компанид,
- 2001-2005 онд аймгийн Хөдөлмөр Эрхлэлтийн албаны дарга,
- 2005-2012 онд аймгийн Хот тохижуулах газрын дарга,
- 2015-2016 онд Орхон МСҮТ-ийн захирал, мөн оноос Орхон аймгийн Эрдэнэт Ус Дулаан Түгээх Сүлжээ ОНӨХК-ийн гүйцэтгэх захирлаар томилогдон үр бүтээлтэй ажиллаж байна.



## "ОНГИ УС СУВАГ" ОНӨААТҮГАЗРЫН ДАРГА ОСОР ОВОГТОЙ ЛХАГВАСҮРЭН



1989 онд Улаанбаатар хотод УБИСургуулийг техник, технологийн багш мэргэжлээр төгссөн. Тэрээр 2008 онд Удирдлагын академийг Бизнесийн удирдлагын менежерээр төгссөн.

О.Лхагвасүрэн нь 1989-1992 онд Өвөрхангай аймгийн Өлзийт сумын ерөнхий боловсролын 8-н жилийн дунд сургуульд техник, технологийн багш, 1992-2002 онд хувийн бизнес эрхэлсэн,

- 2002-2009 онд Өвөрхангай аймгийн "Үлэмж Хурд" ХХК-ний захирал,
- 2009-2011 онд Өвөрхангай аймгийн Тээвэр авто замын газрын орлогч дарга,
- 2011-2013 онд Өвөрхангай аймгийн "Үлэмж Хурд" ХХК-ний захиралаар тус тус ажиллаж байсан.
- 2013 оноос Өвөрхангай аймгийн "Онги Ус Суваг" ОНӨААТҮГазрын даргаар ажиллаж байна.





## “ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Монгол улсад НАА -н салбар үүсч хөгжөөд даруй 86 жил болж байна. Монгол улсын хөгжил дэвшил, ялангуяа барилгажилт хурдтай хөгжиж байгаа өнөө үед орон сууцны салбар маань хүрээгээ улам тэлэн өргөжиж байна.

ОСНАА-н төрийн байгууллагуудтай зэрэгцэн хувийн хэвшлийн компаниудын зах зээлд эзлэх хувийн жин өсөн нэмэгдэж байгаа өнөө үед хувийн компаниудын тус салбар дахь оролцоог нэмэгдүүлэх, чадавхи чадамжийг өсгөх, хэрэглэгчид үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинд үйлчилгээг хүргэх, техник технологи болон үйлчилгээний нэгдсэн стандарт, маркетингийн шинэ бодлого, инновацид тулгуурласан хөгжлийн шинэ шинэ шийдлүүдийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байна.

Ухаалаг болон цахим, автомажсан шийдлүүд хэрэглэгчдэд бүтээгдэхүүн үйлчилгээ хүргэдэг салбаруудын хөгжилд давамгайлах байр суурь эзэлж байгаа энэ үед бид ч хөгжлөөс хоцрохгүй хөл нийлүүлэн алхах шаардлага тулгараад байна.

"ОСНАА Мэргэжлийн Холбоо" ТББ нь гишүүддээ тусалж, дэмжин, тэдний эрх ашгийг хамгаалж, ОСНАА хувийн компаниудынхаа боловсон хүчнийг чадавхжуулах сургалт судалгааны төвийг дэргэдээ ажиллуулах, хөгжингүй орнуудын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын туршлагыг судалж нэвтрүүлэх, мэргэжлийн болон инженер техникийн ажилчдыг чадавхжуулах, гишүүн байгууллагуудынхаа засаглалыг шинэ төвшинд гарган, шинэ стандарт, техник технологи, менежментийн арга барилуудыг нэвтрүүлэх, хууль эрх зүйн орчноо сайжруулах мөн тоног төхөөрөмж, дэвшилтэд техник хэрэгслийн үйлдвэрүүдтэй хамтарч ажиллах гарц, боломжийг нээж өгөх зорилготойгоор 2016 оны 04 сард байгуулагдаад 1 жилийн ажлаа дүгнээд байна. Одоо манай ТББ нь салбарын 41 байгууллагыг эгнээндээ нэгтгэн, үйл ажиллагаагаа явуулж байна.

ТББ-ын тогтвортой үйл ажиллагааг хангах, дүрмийн дагуу зөв хөгжин, гишүүдийнхээ тэгш оролцоог хангах, салбарын хэмжээнд өөрсдийн байр суурийг бататган бэхжүүлэх үүднээс манай ТББ нь дараахь бүтэцтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

### ОСНАА МХ ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



**Чингээ овогтой НИНА** – Хайспийд ХХК-ний Ерөнхий захирал  
ОСНАА салбарт 7 дахь жилдээ ажиллаж байгаа.

**Төгссөн сургууль, мэргэжил, цол**

- 1980-1984 онд ОХУ НЭИС-ийн Автомат холбооны инженер
- 2008 онд ПДС Техникийн ухааны магистр
- 2000-2011 онд Удирдлагийн академи Төрийн удирдлагын бакалавр
- 2013 оноос Монгол улсын зөвлөх инженер

ОСНАА-н салбарт хувийн хэвшлийнхнийг төрд таниулах, ТББ-аараа дамжуулан ОСНАА гишүүн компаниудын чадвар чадавхийг дээшлүүлэх, нэг сатандартай болгох, үйлчлэгч хэрэглэгчдэд үзүүлж буй үйлчилгээнд шинэ техник технологи, программ хангамжийг нэвтрүүлэхэд ТББ-ыг удирдан зохион байгуулах үүрэгтэй ажиллаж байна. 2011 онд "Хувийн ОСНАА хөгжлийн төв" ТББ-ыг санаачлан үүсгэн байгуулалцсан.



## ОСНАА МХ ТББ-ЫН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



**Дэмбэрэл овогтой БАЯРСАЙХАН** - "Таун комфорт" ХХК-ийн  
Гүйцэтгэх захирал

ОСНАА салбарт 15 дахь жилдээ ажиллаж байгаа.

### **Төгссөн сургууль, мэргэжил, цол**

- 1991-1994 онд ТИС БИС-н СҮТ-д сантехникч цахилгаан хийн гагнуурчин
- 1995-2000 онд ТИС БИС-н УХАТ-ын бакалавр инженер
- 2000 онд Техникийн ухааны магистр
- 2011 оноос УХАТ-ын мэргэшсэн инженер
- 2012-2013 онд Удирдлагийн академи Бизнесийн удирдлагын бакалавр

### **Хяналт шинжилгээний зөвлөлийн чиг үүрэг:**

ОСНААМХ-ийн гишүүн байгууллагуудын үйл ажиллагаанд мөрдөх нэгдсэн стандартыг боловсруулж, гишүүн байгууллагууддаа хэрэгжилжүүлэх, биелэлтэнд нь хяналт тавих, гишүүн байгууллагуудын дунд түвшин тогтоох үзлэг шалгалтыг зохион байгуулах, зөрчлийг арилгуулах, салбарт мөрдөх стандарт технологийн хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүрэгтэй. Мөн Мэргэжлийн аварга шалгаруулах уралдааныг гишүүн байгууллагуудын дунд зохион байгуулна.

Орон сууц ашиглалтын байгууллагын процессын баримтжуулалт "төслийг гишүүн байгууллагууддаа нэвтрүүлэхээр судалгааны ажил эхлүүлээд байна.

## ОСНАА МХ ТББ-ЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



**Зундуй овогтой ДАВААЖАРГАЛ** - "Батбаян-Дулаан" ХХК-ны  
Захирал

ОСНАА салбарт 24 жил ажиллаж байгаа.

### **Төгссөн сургууль, мэргэжил, цол**

- 1985-1990 онд ПДС-ийн ЭХФ-ын Дулааны инженер бакалавр
- 2001 онд Техникийн ухааны магистр

### **Мэргэжлийн холбооны дэд зөвлөлийн чиг үүрэг:**

Гишүүн байгууллагуудын өмнө тулгамдаж байгаа Мэргэжлийн чиглэлийн УХАТ, дулаан хангамж, цахилгаан хангамжийн асуудлуудыг шийдвэрлэх, төрийн болон хангагч байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах, хэлэлцүүлэг хийх гэх мэтээр шаардлагатай асуудлуудыг хөндөн, төр засгийн анхааралд хүргэх чиг үүрэгтэй.

2017 оныг "Төр хувийн хэвшлийн түншлэлийн жил" уриатайгаар эхэлж, одоогоор БХБЯ, УБДС ТӨХК, МНААҮХ ТББ, ХСУХАТАҮЗЗ зэрэг газруудтай хамтран ажиллах саналаа хүргүүлж, хамтын ажиллагааны төлөвлөгөөгөө боловсруулан зөвшилцөх гараагаа эхлээд байна.



## ОСНАА МХ ТББ-ЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



**Гэлэн овогтой САРАНТУЯА** – "Хайспийд" ХХК-ний Хуулийн зөвлөх

Хууль, хяналтын салбарт 18 дэхь жилдээ ажиллаж байна.

### **Төгссөн сургууль, мэргэжил, цол**


- 1990-1994 онд "Хуулийн дунд сургууль" хуульч
- 1997-2001 онд "Халх журам" ХЗДС Эрх зүйч, хуульч бакалавр
- 2006-2008 онд МУИС-ийн Хууль зүйн их сургууль Магистр

### **Хууль зүйн дэд зөвлөлийн чиг үүрэг:**

Салбарын болон ОСНААМХ, гишүүн байгууллагуудад шаардлагатай хууль эрх зүйн актуудыг бүрдүүлэх, сурталчлах, гишүүддээ тайлбар зөвлөмж өгөх, шинээр боловсруулагдан буй хууль эрх зүйн актуудад гишүүдийн саналыг нэгтгэн хүргүүлэх, ОСНААМХ-ний Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөл, Гүйцэтгэх захиралын болон Дэд зөвлөлийн боловсруулан гаргаж буй дүрэм журмыг хянан хууль зүйн хүрээнд байхад гол анхаарлаа хандуулан ажиллана.

Одоогоор ТББ-ын дотоод журам, "Дэд зөвлөлүүдийн дотоод журам"-ыг боловсруулаад байна. СӨХ-ийн хуулийн шинэчлэлтэнд гишүүдийн саналыг тусган БХБЯ-д хүргүүлсэн.

## ОСНАА МХ ТББ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



### **Цэрэндэмбэрэл овогтой ДЭЭДЭНЦЭЦЭГ**

- "Дэнж хотхон" ХХК-ийн Захирал

ОСНАА салбарт 32 дахь жилдээ ажиллаж байна.

### **Төгссөн сургууль, мэргэжил, цол**

- 1980-1985 онд ПДС-ийн ЭХФ-ийн Дулааны инженер
- 2000 онд Техникийн ухааны магистр

### **Ёс зүйн дэд зөвлөлийн чиг үүрэг:**

ОСНАА салбарын ажиллагсадын соёлтой үйлчилгээний харилцааны стандартыг боловсруулах, гишүүн байгууллагуудын санал гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, зах зээлийн өрсөлдөөний явцад гарсан маргааныг эвээр зохицуулж, цаашид гишүүдийн эвсэг, хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлэх чиг үүрэгтэй ажиллана.

Одоогоор ШӨХТГ-тай санал солилцон, зах зээлийн нөхцөлд төр болон хувийн байгууллагуудын тэгш харилцаа, хандлагыг хэрэгжүүлэх тал дээр анхаарлаа хандуулан ажиллаж байна.





## ОСНАА МХ ТББ-ЫН МАРКЕТИНГ СУРТЧИЛГААНЫ ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



**Хадбаасан овогтой БАДАМЦЭЦЭГ** - "Бадамлах нар" ХХК-ийн Ерөнхий захирал

ОСНАА салбарт 10 дахь жилдээ ажиллаж байна.

**Төгссөн сургууль, мэргэжил, цол**

- 1992-1997 онд УБ ТЗ-ын Холбооны техникчийн анги
- 1995-1997 онд ХМДС-ын Холбооны ашиглалтын инженер
- 2014-2015 онд Удирдлагын академийн Бизнес удирдлагын бакалавр

**Маркетинг сурталчилгааны дэд зөвлөлийн чиг үүрэг:**

ОСНААМХ-ний [www.osnaamx.mn](http://www.osnaamx.mn) нэгдсэн вэб сайт болон гишүүн байгууллагуудын вэб сайтын ажиллагааг байнгын ажиллагаатай байлгах, гишүүдийн хэрэглэгчдийн үйлчилгээнд зориулсан сурталчилгааны ажлуудыг зохион байгуулахад чиглэл өгөх, ОСНААМХ болон гишүүдийн үйл ажиллагаа, амжилт ололтыг хэвлэл мэдээллээр сурталчлах, гишүүн байгууллагуудын хооронд урлаг спортын идэвхжүүлэлтийн арга хэмжээг зохион байгуулах, хүрээгээ өргөтгөх чиг үүрэгтэй ажиллана.

## ОСНАА МХ ТББ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



**Батаа овогтой ТУЯАЖАРГАЛ** : ОСНАА МХ ТББ-ЫН СУРГАЛТ СУДАЛГАА,ДОТООД АЖЛЫН ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Мэргэжлийн боловсролын салбарт 6 жил, ОСНАА салбарт 8 дэх жилдээ ажиллаж байна.

**Төгссөн сургууль, мэргэжил, цол**

- 1999-2003 онд ТИС БИС-ийн Сантехникийн инженер
- 2003 онд Техникийн ухааны магистр
- 2014 онд Үндэсний сургагч багш
- 2015 онд Сантехникийн мэргэшсэн инженер

**Дотоод ажлын дэд зөвлөлийн чиг үүрэг:**

ТББ-ын дотоод бичиг хэрэг, санхүү, хурал зөвлөгөөнийг зохион байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөө, биелэлт, тайланг гаргах, хурлын зар, шийдвэрийг гишүүддээ хүргэх, сурталчлах, хэрэгжүүлэлтэнд хяналт тавих, гишүүдээс санал хүсэлт хүлээн авах зэрэг үндсэн чиг үүрэгтэй болно.

Одоогоор Бүх гишүүдийн хурлыг нэг удаа, УЗ-ын хурлыг 2 удаа, ХЗ-ийн хурлыг 1, Дэд зөвлөлүүдийн хурлыг нэг нэг удаа зохион байгуулаад байна.



### **Сургалт судалгааны дэд зөвлөлийн чиг үүрэг:**

Гишүүн байгууллагуудын ажиллагсадын мэдлэг, чадавхи чадамжийг дээшлүүлэх болон мэргэжил эзэмшүүлэх сургалтуудыг зохион байгуулах сургалтын төвийн үйл ажиллагааг хариуцахын зэрэгцээ ОСНААМХ-ийн төрөлжсөн судалгааг нэгтгэн судалгааны сантай болно. Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаад болон дотоодын байгууллагуудын туршлагыг судалж нэвтрүүлэх чиглэлээр ажиллана.

Сургалтын эрх авах бичиг баримтын бүрдлийг хангаад зохих шатанд асуудлаа тавьсан байгаа бөгөөд Германы ижил төстэй ТББ-тай холбогдон хамтран ажиллах хүсэлт гаргаад байгаа болно.

Бидний зорилго, бодлоготой хөл нийлүүлэн алхах хувь хүн, ААН, бусад холбоодын өмнө манай хаалга нээлттэй байх болно.

2017 оны Нийтийн аж ахуйн салбарын Удирдах ажилтны зөвлөлгөөнд хүрэлцэн ирсэн нийт зочид төлөөлөгч, тус салбарт амаргүй, цаггүй, ачаалалтай, стресстэй боловч нийслэлийнхээ ард иргэдийг галыг манаж, чандмань эрдэнэ усаар хангаж, бохир бүхнийг зайлуулах буянт үйлсдээ шургуу хөдөлмөрлөж байгаа мэргэжил нэгт нөхөддөө Гишүүн байгууллагуудынхаа хамт олны өмнөөс цаашдын ажил хөдөлмөртөө амжилт бүтээлийг дагуулан, эрч хүчтэй хамтран ажиллахыг хүсье.

ОСНААМХ ТББ-ын Тэргүүн **Ч.НИНА**



## “ХУВИЙН ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН ХӨГЖЛИЙН ТӨВ” ТББ - ын ТОВЧ ТАНИЛЦУУЛГА



### ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.ДЭЛГЭРМЭНД

Манай байгууллага нь Улаанбаатар хотод ОСНАА-н үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн компаниудын санаачилгаар байгуулагдаж, 2013 оны 03-р сард улсын бүртгэлд бүртгүүлэн албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд Удирдах зөвлөлийн даргаар Б.Туул, Гүйцэтгэх захирлаар Ж.Дэлгэрмэнд нар ажиллаж байна .

Одоогийн байдлаар Улаанбаатар хотод 70 гаруй ОСНАА-н Үйлчилгээний тусгай зөвшөөрөл бүхий хувийн ОСНАА-н үйлчилгээний компаниуд үйл ажиллагаа явуулдгаас 30 гаруй компани манай байгууллагын гишүүн болоод байна.

### ЭРХЭМ ЗОРИЛТ:

Монгол улсын ОСНАА-н Үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байгаа Хувийн хэвшлийн байгууллагуудыг хөгжүүлэх, тэдний үүрэг оролцоог нэмэгдүүлэх, салбартаа шинэ техник технологийг нэмж нэвтрүүлэх, салбарынхаа хөгжил дэвшил, нэр хүндийг өсгөхөд хувь нэмрээ оруулах нь үнэт зүйл болно.

### ЭРХЭМ ЗОРЛГО:

ОСНАА-н Үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж шинэ түвшинд гаргах, гишүүн байгууллагуудынхаа чадавхи чадамжийг өсгөх, тэдэнд тулгамдсан асуудлуудыг судлан боловсруулж холбогдох байгууллагуудад тавих, гишүүн байгууллагуудад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт семинар зохион байгуулах, гадаад дотоодын ижил төстэй байгууллагуудтай холбох, хууль эрх зүйн дүрэм журам, мэдээллийг цаг алдалгүй хүргэх тэдний эрх ашгийг хамгаалахад оршино.







## МЭНДЧИЛГЭЭ



70 жилийн түүхтэй ОСНАА –н салбартаа хоногийн хорин дөрвөн цагт хоромхон ч зогсолгүй, халуун хүйтэн, хатуу хөтүүг үл ажран их хотынхоо иргэд, оршин суугчдын тав тухтай амьдралын төлөөх манаанд сэтгэл зүрхээ нэгтгэн, өөрийн хүч хөдөлмөр, эрдэм мэдлэгээ зориулан, хэтэрхий далд гэмээр далд оршиж хамгийн их үүрэг хариуцлагыг үүрэн ажиллаж байгаа мэргэжил нэгт та бүхэндээ удирдах ажилтны зөвөлгөөндөө амжилттай оролцохыг хүсэн мэндчилье.

Та бид оршин суугчид хэрэглэгчдээ ус, дулаантай, голомтыг нь илч гэрэлтэй байлгах үүрэг хүлээсэн Орон сууц нийтийн аж ахуйн салбарынхан билээ..

Орон сууцны салбар маань ч улам өргөжин тэлсээр Хувийн орон сууц ашиглалтын компаниуд 2001 оноос байгуулагдан өдгөө 70 гаран байгууллагууд энэ хүндтэй ажил үйлсэд хамтран ажиллаж байгаа ба одоогоор 30 - аад компани манай ХОСНАА-н ХТөвд гишүүнээр элсээд байна.

Хэний ч анзаарамгүй эгэл атлаа хэн ч хүндэлмээр гайхамшигт үйлийн эзэд болсон нийтийн аж ахуйн салбарын удирдлагууд, албан хаагчид та бүхэндээ ард олныхоо төлөө хүлээсэн их үүргээ нэр төртэй биелүүлж нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй хүчирхэг салбар болгохын төлөө хамтран зүтгэж ажил үйлсдээ улам их амжилт гаргахыг хувиасаа болон ХОСНААХТөвийн хамт олны зүгээс хүсэн ерөөе .

Монгол улсад НАА-н салбар үүсч хөгжсөний 85 жилийн ойн баярын "Хүндэтгэлийн концерт"-ыг "Эрчис фильм" ХХК-тай хамтран 2016 оны 10-р сарын 14-ний өдөр амжилттай зохион байгууллаа.

Бид жил бүр хувийн компаниудынхаа дунд спортын тэмцээн, шинэ жилээ хамтран зохион байгуулж ирсэн. Мөн 2015 оноос урлагийн наадам зохион байгуулахаар тогтсон ба 2 жил дараалан урлагийн авьяастнуудаа шалгаруулан шинэ жилийн арга хэмжээндээ урьж оролцуулдаг уламжлал тогтоод байна.

Удирдах зөвлөлийн дарга **Б.ТУУЛ**





## “БАДАМЛАХ НАР” ХХК-ИЙН 10 ЖИЛИЙН АЖЛЫН АМЖИЛТ ТҮҮХЭН ЗАМНАЛААС:



Бадамлах Нар ХХК нь 2006 онд "Алтай Констракшн" ХХК-ны барьж ашиглалтанд оруулсан "НАРХАН" хотхоны ашиглалт үйлчилгээг хариуцан ажилласнаар ажлын гараагаа эхэлсэн билээ. "БАДАМЛАХ НАР" ХХК нь өнөөдрийг хүртэл Удирдлага, санхүү-8, Инженер техникийн ажилтан-15, Мэргэжлийн ажилчин-25 нийт 48 ажилтантай орон сууц ашиглалтын чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

"НАРХАН" хотхоны оршин суугчдын хүсэлтээр "НАРХАН СӨХ"-ийг байгуулж СӨХ-ийн үйл ажиллагааг давхар хариуцан ажиллаж эхэлснээр бидний хувьд их бүтээн байгуулалтын жилүүд өрнөсөн. Бид Улаанбаатар хотынхоо Хан-Уул дүүрэгт баригдаж ашиглалтанд орсон НАРХАН хотхон, АЛТАЙ ХАУС хотхон, Зайсан-26, ЭЛИТ хотхон, Баянзүрх дүүргийн 26-р хороонд баригдан ашиглалтанд орж байгаа САРУУЛ хороололыг тус тус хариуцан ажиллаж байгаа бөгөөд дараах төрлийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

- Үүнд:
- Орон сууцны ашиглалт үйлчилгээ
  - СӨХ-ийн ашиглалт үйлчилгээ
  - Харуул хамгаалалтын үйлчилгээ
  - Сантехник, цахилгааны угсралт

### **Түүний нэгээхэн хэсгээс дурдвал:**

ХХОСНАА-н "БАДАМЛАХ НАР" ХХК нь Нархан хотхоноо бүрэн камержуулж, грашийн дээд талын тоглоомын талбайг шинээр битүү хучилт хийж 100% засварласан. Мөн дээврийн ажлыг шинэчлэж, цэвэр усны шугам болон дулааны шугамыг өргөтгөн, ЦТП-дээ халуун усны ялтсан бойлуурыг нэмж суулгасанаар цэвэр болон халуун усны асуудлыг бүрэн шийдвэрлэж чадсан билээ.







Гражийн дээврийн тоглоомын талбайд бхб хэмжээтэй иж бүрэн вакум цонхтой, сандал ширээтэй, тохилог байр барьж төмөр хашаатай саравч барьж тохижуулсан. Хотхоны зам талбайг сэргээн засварлаж, машин орж гарах аюулгүй үүднээс хурд сааруулагчийг хийж өгч, гадна гэрэлтүүлгийг нэмж шинээр хийж тохижилтыг сайжруулсан.

Гражийн хаалгыг автоматжуулж дундын өмчлөлийн цахилгааны төлбөрийг хэмнэх зорилгоор хотхоны 7 байрны 24 орцны үүд болон давхарт бүрд мэдрэгчтэй гэрлийг хийснээр цахилгааны төлбөрөө 30 хүртэлх хувиар бууруулж чадсан. Мөн энэ онд хотхоны аюулгүй байдлыг хангах үүднээс хамгаалалтын камеруудыг нэмж байрлуулан хуучин камеруудыг засварлан бүрэн ажиллуулж оршин суугчдынхаа ая тухтай байдлыг хангах үүднээс НОГООН ХОТХОН төслийн хүрээнд Улаанбаатар цэцэрлэгжилт компанитай хамтран ажиллаж 2700ширхэг бут суулгаснаар хотхоны өнгө үзэмжинд чимэг нэмэн "БҮТЭЭЛЧ" хамт олон өргөмжлөлийг хүртсэн

#### **Энэ хугацаанд хийгдсэн томоохон ажлуудаас товч танилцуулвал:**

Урсгал засвараар халуун хүйтэн усны магистрал шугамны 40-ын хаалтуудыг бөмбөлөгөн хаалтаар сольж, босоо магистрал шугамны 25, 32,40 –ын хаалтуудыг сольж шинэчлэсэн.

Нархан хотхон, Алтай хаус, Зайсан, 26-р байрнуудад зуны урсгал засварын ажлаар нийтдээ 996 метр халуун хүйтэн усны гол шугам, буцах шугамыг сольж, бөмбөлөгийн хаалт 30 ширхэгийг шинээр тавьсан.

-Мөн дулаалга хучилтын хавтан хийж, халаалтын магистрал шугам дээр шинээр хаалт хийснээр, дулаан алдалтыг багасгаж, оршин суугчдын гомдлыг 100 хувь шийдэж чадав.

Энэ жилүүдэд бид тодорхой мэдлэг, туршлага, арга барилтай болж хамт олон маань мэргэжлийн олон чадварлаг залуучуудаар өргөжин тэлж шилдэг залуу хамт олныг бүрдүүлэн ажиллаж байна. 2012, 2013, 2014, 2015 онуудад хувийн хэвшлийн компаниудын дунд зохиогдсон сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнд 1,2-р байруудыг тус тус эзлэн баг хамт олноороо тэргүүн байр шилжин явах цомоор шагнагдаж, 2012 онд НАА төвийн бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс багаараа шилжин явах цом алтан медаль өргөмжлөл, 2013 онд Хөгжлийн төвөөс зохион байгуулсан сагсан бөмбөгийн тэмцээнд эмэгтэй баг тамирчид 1-р байр, эзэлж алтан медаль өргөмжлөлөөр тус тус шагнагдаж байсан.

Хамт олныхоо дунд спорт урлагийн наадам зохиож, гар бөмбөг, сагс, теннис, шатар, даам, караокены төрлөөр өрсөлдүүлж байгууллагын аваргуудаа тодрууллаа. Үүнд – Нархан, Саруул, Алтай, Зайсан гэсэн 4 багийн нийт баг тамирчид амжилттай оролцов.











**Бадамлах Нар ХХК-ны нийт баг хамт олон**



Манай байгууллагын хамт олон урлаг спортоороо шилдэгийн шилдэгүүд байж чаддаг сайхан хамт олон юм. Караокены тэмцээнд тэргүүн байр эзэлсэн **НАРХАН** багынхандаа баяр хүргэе.

**НАРХАН БАГ:**



**АЛТАЙ БАГ:**



**САРУУЛ БАГ:**



**БИДНИЙ АМЖИЛТ:**





Нархан, Саруул хороололд ОСНАА -өдөрт зориулсан нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан.

Бид архивын материал зураг, мэндчилгээ ажлын байрны зураг авалт аар , богино хэмжээний баримтат кино хийлгэв.

Манай хамт олон чөлөөт цагаа хөгжилтэй,зугаатай өнгөрөөж чаддаг цоглог хамт олон юм.



Бидний сэтгэл , зүтгэл гар нийлсэн хамт олноос амжилт бүтээл ундарч, оршин суугч айл өрхөө ая тухтай амьдралыг нь бүрдүүлж буйгаараа манайхан бахархдаг.Хотхондоо ая тухтай амар амгалан сайхан орчинг буй болгосноороо бид бас та бүхэнтэй хамт сэтгэл хангалуун байх болно.Сайн сайхан дэлгэрч , айл өрх бүр аз жаргалтай гал голомт нь үргэлж бадран мандаж явахын ерөөл өргөж мэргэжил нэгт нөхөд та бүхэндээ ажлын амжилт хүсье.

**БАДАМЛАХ НАР ХХК-ийн Захирал: Х.БАДАМЦЭЦЭГ**



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ЯАМ

# ДАРХАН ХОТЫН БОХИР УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН МОН-3244 /МОН-3245 ТӨСӨЛ



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

## А. Зээл болон төслийн хураангуй

**АХБ-ны зээлийн дугаар:**

МОН-3244/МОН-3245

**Зээлдэгч:**

Монгол Улсын Засгийн газар

**Хариуцагч байгууллага:**

Барилга, хот байгуулалтын яам

**Хэрэгжүүлэгч байгууллага:**

Дархан-Уул аймгийн захиргаа (ДУАЗ)

**Зээлийн гэрээнд гарын үсэг зурсан өдөр:**

2014 оны 12-р сарын 16-ны өдөр

**Зээлийг соёрхон баталсан өдөр:**

2015 оны 6 -р сарын 05-ны өдөр

**Зээл хүчин төгөлдөр болсон өдөр:**

2015 оны 8-р сарын 25-ны өдөр

**Зээл дуусгавар болох өдөр:**

2019 оны 6-р сарын 30-ны өдөр

**Төслийн нийт өртөг:**

20.68 сая ам.доллар

**Үүнээс АХБ-ны санхүүжилт:**

18.50 сая ам.доллар

**АХБ-ны зээлийн нөхцөл:**

Үндсэн 2 эх үүсвэрт зээлүүд нь 25 жилийн хугацаатай байх бөгөөд эхний 5 жилдээ үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөнө. Ердийн хөрөнгийн эх үүсвэрт зээл нь Лондонгийн Банк хоорондын арилжаанд санал болгодог хүүд суурилан тооцсон жилийн суурьт хүүтэй байх ба, хөрөнгө хадгалсны хураамж болох 0.15%-ийг жилд төлнө. Азийн хөгжлийн сангийн эх үүсвэрт зээлийн хувьд үндсэн зээлийн төлбөрөөс чөлөөлөгдөх жилүүд болон зээлийг буцаан төлөх нийт хугацаанд жилд 2 хувийн хүү тооцно.

**АХБ-ны зээлийн үндсэн төлбөрийг эргүүлж төлөх нөхцөл:**

Төлбөрийг 2020 оноос эхлэн жил бүрийн 2 дугаар сарын 25 ба 08 дугаар сарын 25-ны өдөр төлнө.

**Дамжуулан зээлдүүлэх нөхцөл:**

Засгийн газар ЕХЭҮ-т болон АХС-ийн зээлийн эх үүсвэрийг Дархан-Уул аймгийн захиргаанд дамжуулан зээлдүүлнэ. Энгийн эх үүсвэрийн зээл, хөнгөлөлттэй эх үүсвэрийн хүү тогтмол байх бөгөөд 3.75 хувийн хүүг ашиглалт гарсан өдрөөс эхлэн тооцно. Дамжуулан зээлдүүлсэн зээлийг үндсэн төлбөрийг хойшлуулах 4 жилийг оролцуулан 20 жилийн хугацаанд төлөх бөгөөд анхны төлбөрийг 2020 оноос эхлэн жил бүрийн 06 дугаар сарын 01 ба 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд Сангийн яаманд төлнө.



## Б. Төслийн зорилго

Монгол улсын Дархан-Уул аймаг (хотын) байгаль орчинд тогтвортой нөлөө бүхий хот байгуулалтыг дэмжиж стандартын чанар аюулгүй байдал үзүүлэлтийн түвшинг хамруулж, амьдралын хэм хэмжээ төлөв байдал сайжирна. Төсөл нь Монгол улсын 2 дах том хотод хот хөдөөгийн харилцан шүтэлцлийг бэхжүүлсэн хотын хийгээд үйлдвэрлэлийн хөгжилд түлхэц болсон хотжилтын тэнцвэрийг үндэсний хэмжээнд хангах чиглэлд хувь нэмэр оруулна.

Төслөөр Дархан хотын бохир усны менежмент сайжирч, бохир ус цэвэрлэх төв байгууламж (ТЦБ), ариутгах татуурга болон насосны станцын үйл ажиллагааны түвшинг дээшлэхэд дэмжлэг үзүүлнэ. Мөн төслөөр Дарханы ус сувгийн байгууллагын менежментийн, чадавхийг бэхжүүлэх, сургалтын болон бодлогын хэлэлцүүлгээр дамжуулан дэмжлэг үзүүлнэ. Мөн Монгол улсын Дархан-Уул аймгийн Дархан сумын НАА-н байгууллагуудыг бэхжүүлэх, бүтцийг оновчтой боловсронгуй болгох үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглүүлэн Техникийн туслалцааг хэрэгжүүлнэ.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхэд төслийн удирдах нэгж зохицуулагч, худалдан авалт хариуцсан ажилтан, санхүүгийн ажилтан, захиргааны туслах ажилтан, орчуулагч, жолооч нарын орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж төслийн хэрэгжилтийг хангуулж байна.




## В. Төслийн үр дүн

### **Үр дүн 1: Бохир ус цэвэрлэх байгууламж сайжирна.**


Төслийн үр дүнд одоогоор ашиглагдаж буй цэвэрлэх байгууламжийн хийцийн хувьд чанарын шаардлага хангаагүй хэсгүүдийг шинэчлэх, зарим шинэ бүрдэл хэсгүүдийг талбай дээр шинээр барих болон нийт байгууламжийн хэмжээнд шинэ тоног төхөөрөмж суурилуулах замаар Дархан хотод орчин үеийн Төв Цэвэрлэх байгууламжийг ашиглалтанд оруулна. Шинэ, бүтээмж өндөртэй бөгөөд эрчим хүчний хэмнэлттэй цэвэрлэх процесс болох биофильмт технологийг (идэвхижүүлсэн лаг) ашиглаж эхлэнэ. Энэ нь манай орны эрс тэс уур амьсгалд зохицсон бөгөөд ЦБ-аас хаягдах усны чанар дээшилж, дотоодын болон олон улсын стандартын шаардлагуудыг хангах болно. Цэвэрлэх хүчин чадлын өдрийн хэвийн үеийн ачаалал нь 16,000 шоо метр бохир ус ариутгах ба оргил ачаалал нь өдрийн 24,000 шоо метр байна.



**Одоогийн идэвхижүүлсэн лагийн цэвэрлэх байгууламж**



**Шинэ цэвэрлэх байгууламжийн төлөвлөтийн тойм зураг**








## Үр дүн 2: Насос станцууд ба бохирын шугам хоолой шинэчлэгдэнэ.

Төслөөр хуучирч муудсан 5,300 км урт бохир усны шугам хоолойг шинэчлэх бөгөөд энэ нь өмнө уг аймагт улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэхэд оруулсан хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн үргэлжлэл болж байгаа юм. Одоогоор ашиглагдаж буй 2 насос станцыг бүрэн шинэчилж тоногосноор цэвэрлэх байгууламжид төвлөрөх бохир усны цуглуулалтыг ихэсгэж илүү эрчим хүчний хэмнэлттэйгээр цэвэрлэх боломжийг бий болгоно.

## Цэвэрлэх байгууламжийн урьдчилсан төлөвлөлтийн технологийн схем



## Үр дүн 3: Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх.

(i) Төслийн менежмент, институцийг бэхжүүлэх

НАА-н салбарын менежментийн чадавхийг хөгжүүлэх, ашиглалт ба засвар үйлчилгээг сайжруулах, онцгой байдлын үед авах арга хэмжээг нарийвчилсан зураг төсөл боловсруулан хэрэгжүүлэх, түүнд хяналт тавьж мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажиллах.

(ii) Төслийн удирдах нэгжийн чадавхийг бэхжүүлэх

Төслийн хэрэгжилтийн явцад сургалт болон сургалтын аялалууд зохион байгуулагдана. Төслийн явцад цэвэр ба бохир усны үнэ тарифын шинэчлэл, ариун цэврийн орчин болон хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар бодлого тодорхойлох яриа хэлэлцүүлэг хийнэ. Байгаль орчны менежмент, ариун цэвэр ба хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах талаар олон нийтийг хамруулсан компани ажил зохион байгуулна.

Төсөл хэрэгжүүлэхтэй зэрэгцүүлэн НАА-н үйлчилгээний институци бүтцийг хөгжүүлэх, стратеги төлөвлөлт ба үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн Техникийн туслалцааны төслийг хэрэгжүүлнэ.



## Г. Өртөг ба санхүүжилт

Төслийн нийт өртөг нь 20,68 сая америк доллар байх ба үүнд барилгын ажлын болон үнэ ханшийн өсөлт, магадлашгүй зардлууд, зээлийн хүү, татвар болон бусад хураамжууд багтсан болно. АХБ-ны зээлээр цэвэрлэх байгууламжийг (зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж угсарч суурилуулах гэсэн схемээр 1 багц, барилгын ажил ба тоног төхөөрөмжийн 2 багц, зөвлөх үйлчилгээний 1 багц, хүү болон хөрөнгө хадгалсны хураамж) зэргийг санхүүжүүлнэ. Засгийн газар татвар хураамж, газар чөлөөлөлт ба нүүлгэн шилжүүлэлтийн зардал зэргийг дотоодын санхүүжилтээр гүйцэтгэнэ.

### Төслийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө

(сая ам доллар)

<i>Төрөл</i>	<i>Үнийн дүн</i>
А. Суурь өртөг	
1.Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх	15.00
2.Насос станц ба бохирын шугам хоолойн шинэчлэл	1.67
3.Төслийн менежментийн дэмжлэг ба чадавхийг бэхжүүлэх	1.80
Дэд дүн (А)	18.47
Б. Магадлашгүй зардлууд	1.51
В. Төсөл хэрэгжих явцын санхүүгийн хураамжууд	0.70
Нийт (А+Б+В)	20.68

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрийн дагуу Банк нь Монгол Улсад дээрх зээлийн хэлэлцээрт тусгагдсан нөхцөл болзолын дагуу 9,450,000.00 ам.доллартай тэнцэх энгийн эх үүсвэрийн зээл, 6,159,000.00 зээлжих тусгай эрхтэй тэнцэх 9.050,000.00 ам долларын хөнгөлөлттэй эх үүсвэрийн зээлийг олгохыг зөвшөөрсөн.

### Төслийн санхүүжилтийн төлөвлөгөө

(сая ам доллар)

<i>Эх сурвалж</i>	<i>Үнийн дүн</i>	<i>Нийт дүнд эзлэх (%)</i>
Азийн хөгжлийн банк		
Ердийн хөрөнгийн эх үүсвэр (зээл)	9.45	46
Тусгай сангийн эх үүсвэр (зээл)	9.05	44
Монгол улсын Засгийн газар	2.18	11
Нийт	20.68	100



## АХБ-НЫ БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ/ЗЭЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ӨМНӨГОВЬ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН ОЙРОЛЦОО СУУРИН ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэгдүгээр үе шат

G0204-МОН

(2011-2017)

Буцалтгүй тусламж

Хоёрдугаар үе шат

L3388-МОН

(2016-2019)

Нэмэлт санхүүжилт

Төслийн зорилго:	Төсөлд хамрагдсан хотуудын хөгжлийг үр ашигтай, зөв төлөвлөх, чанартай, найдвартай, өргөн хүрээг хамарсан нийтийн аж ахуйн үйлчилгээ, дэд бүтцийг хөгжүүлэх	Бүрэн биологийн цэвэрлэгээний, өндөр бүтээмжтэй цэвэрлэх байгууламжуудыг барьж, ашиглалтад өгөх
Хамрах хүрээ:	Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд, Цогтцэций, Гурвантэс болон Дорноговь аймгийн Сайншанд, Замын Үүд сум	Арвайхээр, Даланзадгад, Цэцэрлэг Сайншанд хотууд
Онцлог:	Төслийн сумдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, нэн тэргүүнд шаардагдах дэд бүтцийн барилга байгууламжийг барих, ашиглалт үйлчилгээг хариуцах оператор компанийг байгуулж чадавхжуулах зэрэг ажлуудыг хамарсан цогц шийдэл	Төслийн хотуудад Био өнгөр тогтоогч бүхий идэвхит лагийн технологи нэвтрүүлнэ.

### I үе шат. Буцалтгүй тусламжийн ажил G0204-МОН.

#### 1. Цэвэр ус, дулаан хангамж, бохир усны цэвэрлэгээний системийн ажлууд хийгдсэн.

##### *Дорноговь аймагт*

Сайншанд хотод 6.81 км цэвэр усны шугам, 5.021 км бохир усны шугам, 4.4 км дулааны шугам угсарч, ашиглалтанд оруулсан.

Сайншанд хотод 8,4 МВт хүчин чадалтай дулааны зуух, дагалдах насос, тоног төхөөрөмж, зуухны барилга, харуулын байр, цахилгаан дамжуулах дэд станц, дизель цахилгаан үүсгүүр, хамгаалалтын хашаа барьж, хүлээлгэн өгсөн.

Замын Үүд суманд 13.45 км цэвэр усны шугам, 7.87 км бохир усны шугам угсарч, 3 ш ус түгээх байр, 2 ш бохир усны насосны станц барьж, ашиглалтанд оруулсан.

Замын Үүд суманд 6.22 км дулааны шугам угсарч, 3 ш дулаан дамжуулах төв, 3 ш дизель цахилгаан үүсгүүр барьж, хүлээлгэн өгсөн. Замын Үүд сумын 2 цэцэрлэг, 1 дунд сургуулийг холбох 1,2 км дулааны шугам угсралт, хатуу хаягдлын хүнхээл бэлтгэх ажил.

##### **Өмнөговь аймагт**

Даланзадгад хотод 1,000 м3 усан сан, 1.4 км цахилгаан дамжуулах шугам, гүний худаг, 1.422 км ус дамжуулах шугам, гэр хороололд 4.66 км бохир усны шугам угсарч, ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

Гурвантэс суманд 100 м3 багтаамжтай усан сан, 2 ш гүний худаг, 3.2 км цахилгаан дамжуулах шугам, 5.49 км цэвэр усны шугам, 4.14 км бохир усны шугам, бохир ус цэвэрлэх байгууламж, 3 ш ус түгээх байр барьж, ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

Ханбогд суманд 5.49 км цэвэр усны шугам, 8.43 км бохир усны шугам, 5.4 км цахилгаан дамжуулах шугам, 2 км дулааны шугам, 2 ш ус түгээх байр, бохир ус цэвэрлэх байгууламж барьж, ашиглалтанд хүлээлгэн өгсөн.

Цогтцэций суманд 2 ш 100 м3 багтаамжтай усан сан, 0.6 км цахилгаан дамжуулах шугам, 3 ш ус түгээх байр, бохир усны насосны станц, 6.6 км цэвэр усны шугам, 5.76 км бохир усны шугам барьж, ашиглалтанд хүлээлгэн өгсөн.








## 2. Авто замын барилгын ажил.

Шинэ Сайншанд хороололд 2.0 км авто зам барьж, хүлээлгэн өгсөн. Гурвантэс суманд 2 км хатуу хучилттай авто зам, 1.8 км үерийн далан, Цогтцэций суманд 2 км хатуу хучилттай авто зам барьж, ашиглалтанд хүлээлгэн өгсөн.



## 3. Хатуу, хог хаягдлын машин механизм нийлүүлж, хог пресслэгч суурилуулсан.



Сайншанд суманд: 5 тн нягтруулагчтай хог тээвэрлэх автомашин  
Бохир ус тээвэрлэх автомашин /4 тн/

Цогтцэций суманд: 3 тн нягтруулагчтай хог тээвэрлэх автомашин  
Бохир ус тээвэрлэх автомашин /4 тонн/

Замын Үүд суманд: Хогийн контейнер тээвэрлэх зориулалттай дэгээтэй автомашин

Ханбогд суманд: Бохир ус тээвэрлэх автомашин /4 тонн/

Гурвантэс суманд: 1,8 м<sup>3</sup>-ын шанага бүхий ковш  
3 тн нягтруулагчтай хог тээвэрлэх автомашин



## 4. Зөвлөх үйлчилгээ

Дорноговь аймгийн Сайншанд сум, Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций, Гурвантэс сумдын 2025 он хүртэлх “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” болон “Шинэ Сайншанд” орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулж, орон нутагт 2015.08.24-нд хүлээлгэн өгсөн.

Орон нутаг оператор компаниудтай байгуулах түрээсийн гэрээ, үнэ тариф, түрээс болон татаасын хэмжээг тусгасан санхүүгийн тооцоо, үйл ажиллагааны ашиглалтын гарын авлага боловсруулсан. Шинээр байгуулагдсан оператор компаниудад ашиглалт, үйлчилгээ явуулах танхимын болон газар дээрх сургалтыг хийсэн.



**II үе шат. Зээлийн төсөл L3388-МОН. Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна**

Засгийн газрын мөрийн хөтөлбөр, АХБ-ны 2020 оны стратегийн дунд хугацааны үнэлгээний дүгнэлт, АХБ-ны хот суурины усны менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийцүүлэн хэрэгжүүлнэ. Арвайхээр, Даланзадгад, Цэцэрлэг, Сайншанд хотуудад 3000 м<sup>3</sup>/хоногийн хүчин чадалтай, биологи цэвэрлэгээний байгууламж барих ба төслийн удирдлага, менежментэд туслалцаа үзүүлэх, Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагын чадавхи бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.

Төсөл хэрэгжсэнээр Арвайхээр, Даланзадгад, Сайншанд, Цэцэрлэг хотуудын хүн ам, аж ахуйн байгууллагуудаас гарсан бохир усны цэвэрлэгээний чанар, хүртээмж сайжирч, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө арилна. Төслийн дөрвөн аймгийн төвд бохир ус цэвэрлэх байгууламж барьж, ашиглалтад оруулснаар ижил нөхцөлд байгаа бусад аймгийн төвүүдийн хувьд жишиг болно.

№	Байгууламжийн нэр	Умбуур бодис		БХХ <sub>бүрэн</sub>	
		мг/л	%	мг/л	%
1	Орж ирж буй усанд	80,0	-	180,0	-
2	Нэгдүгээр тунгаагуурын дараа	36-40	50-55	117-126	30-35
3	Аэротенк, хоёрдугаар тунгаагуурын дараа	15-20	75-81,25	7-9	95-96,1
4	Биоцөөрмийн дараа	5-8	90-93,75	3-4	97,7-98,3
	Дундаж цэвэршилт	-	91,87	-	98,0

Төслийн менежмент, удирдлага, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх В.1 багц, Байгууллагын хөгжил ба чадавхийг сайжруулах В.2 багцын зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явагдаж байна. 2017 оны 6-р сард гэрээ байгуулан ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.

**Билл Гейтсийн сангийн техник туслалцааны төсөл**

Билл Гейтсийн сангийн 1 сая ам долларын буцалтгүй тусламжаар төслийн хотуудын гэр хороолол болон цэвэрлэх байгууламжаас гарах лагийн менежментийн сайжруулсан технологи нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.







## МОНГОЛЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХОЛБООНООС 2017 ОНЫ II УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ СЕМИНАР

Хот, орон нутгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын удирдлага болон инженер техникийн ажиллагсдыг бэлтгэх, мэргэжил, мэдлэг, ур чадвар, ёс зүйг дээшлүүлэх мэргэжлийн сургалтыг зохион байгууллаа. Үүнд:

### • "ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА" СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

"Хүний нөөцийн удирдлага" сэдэвт 5 хоногийн сургалтыг зохион байгууллаа. Сургалтаар Хүний нөөцийн менежмент, Хүний нөөцийн менежерийн үндсэн асуудал, Хүний нөөцийн менежерийн баримтлах зарчим, Хүний нөөцийн менежерийн удирдлага зохион байгуулалт, Удирдах ухааны арга барил, ур чадвар, Хүний нөөцийн бодлого стратеги, Хөдөлмөрийн харилцааны ёс зүй, тулгамдаж буй асуудал, Хүний нөөцийн бүрдүүлэлт, оновчтой сонгон шалгаруулалт, Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний систем, Ажлын байрны тодорхойлолт боловсруулах, ээлжийн амралтын олговор тооцох арга зүй, Цалин хөлс урамшууллын систем, Хүний нөөцийн менежмент, Мэдлэгийн менежмент гэх зэрэг нийт 23 цагийн сургалт Хүний нөөцийн удирдлагын академитай хамтран зохион байгуулж, SMART контор "Бат баян дулаан" ХХК-н үйл ажиллагаатай танилцаж туршлага судаллаа.



### • ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ИНЖЕНЕРИЙН ЧАДВАХИЖУУЛАХ СУРГАЛТ" ЗОХИОН БАЙГУУЛЛАА.

Тус сургалтанд орон нутгийн 4 компанийн инженер хамрагдсан бөгөөд сургалтыг мэргэжлийн түвшинд зохион байгуулж мэдлэг олголоо. Сургалтаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, эрх үүрэг, Ажлын байранд эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хурц хордлогын шалтгаан, түүнийг бууруулах арга хэмжээ, ХАБЭА-н удирдлагын тогтолцоо- шаардлага OHSAS 18001 стандарт, Галын аюулгүй байдлын тухай хууль, Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдлийн кино, бичлэг, ХАБЭА-н менежментийн систем, Аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА-н ажлын зохион байгуулалт, Аж ахуйн нэгж, байгууллага дээрх ХАБЭА-н сургалтыг зохион байгуулах журам, Байгууллагын ХАБЭА орчныг сайжруулах" зэрэг нийт 29 цагийн сургалтад хамрагдан батламж гардууллаа.








• "ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР ЦАХИЛГААНЧДЫГ ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ" зохион байгууллаа.

Тус сургалтанд Улаанбаатар, орон нутгийн 8 инженер техникийн ажилтан хамрагдсан бөгөөд сүүлийн үеийн шинэ техник технологитой танилцаж, орчин үеийн тоног төхөөрөмж дээр онол практик хослуулж сургасан бөгөөд, мэргэжлийн зөвлөх инженерүүд хичээл заалаа.



• ОЛОН УЛСАД ЗОХИОН БАЙГУУЛАГДСАН СУРГАЛТ СЕМИНАР.

Салбарын ажлын чиглэлээр олон улсын хурал зөвлөгөөн, үзэсгэлэнд оролцож, хөгжилтэй орны зорилго нэгтэй байгууллагатай хамтран ажиллаж туршлага судлах, харилцаа холбоо тогтоож, тэргүүн туршлага, техник технологитой газар дээр нь танилцаж өөрийн улс орондоо нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс ХБНГерман улсын Берлин хотод 2 жилд нэг удаа зохион байгуулагддаг "WASSER BERLIN INTERNATIONAL 2017"-д НАА-н салбараас 10 хүн оролцоод ирлээ.



Бид салбарын ажилчдад мэдлэг, чадварыг эзэмшүүлэхээс гадна мэргэжлийн зөвлөгөө өгч чадварлаг ажилчидтай болох сонголтыг тань үргэлж дэмжин ажиллах болно.

Мэдээлэл гаргасан Сургалтын мэргэжилтэн  
**Б.Алтантуул**